# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

**Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар** **2022.12.31**

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| **“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| 1. | 1.1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ. | 2021-2024 | ОБГ, ЭМГ | БТ | - | Хяналт шалгалт хийж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байгууллагын тоо-19<br><br>Хамрагдсан иргэдийн тоо - 70 | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-12<br><br>Хяналт шалгалтын тоо-12 | | | 2022 онд Ковид-19 халдварын 2476 тохиолдол бүртгэгдэж, өссөн дүнгээр албан байгууллага, айл өрхүүдийн 2232 объектын 211024 м/кв талбайд халдваргүйжүүлэлт хийж, дотоод орчинд цэвэрлэгээ үйлчилгээг хийх халдвараас сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 15 байгууллагын халдвар хамгааллын дэглэмд хяналт шалгалт хийж, сургалт хийж, 146 ажилчин албан хаагчийг сургалтад хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-15<br>Хяналт шалгалтын тоо-15<br>Хамрагдсан иргэдийн тоо - 146 | 100 |
| 2. | | 2. Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, | 2021-2024 | ОБГ, ЭМГ | БТ | - | Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчи | Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-24<br><br>Хяналт | | | Эрүүл мэндийн байгууллагууд Ковид-19 халдвараас сэргийлэх байнгын болон урьдчилсан халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдөн ажиллаж байна.<br>Төрийн болон орон нутгийн өмчит 14 байгууллагын ариун цэвэр, халдваргүйн горимыг хангах чиглэлээр ариутгалын бодисыг цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэх заавар, зөвлөмжийн талаар мэдээлэл сургалт, сурталчилгаа хийсэн.<br>ЭХЭМҮТөв, Улсын хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран ‘’Халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан” бэлтгэх | 79.2 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалт зохион байгуулах замаар үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | | лгааны тоо-24 ;<br><br>Хяналт шалгалтын тоо-12 | шалгалтын тоо-12 | | | сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр орон нутагт зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн 9 эрүүл мэндийн байгууллагын нийт 45 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулсан.<br>Эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжлэлд орох бэлтгэл ажлын хүрээнд халдвараас сэргийлэх хяналтын шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Нийт давхардсан тоогоор 14 эрүүл мэндийн байгууллагад хяналт шалгалт зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-14<br>Хяналт шалгалтын тоо-14 | |
| 3. | 1.1.2. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдал, хариу арга хэмжээг хангах арга хэмжээг зохион байгуулж, санхүүжилтийг шийдвэрлэнэ. | 3. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана. | 2021-2024 | АОК | ЗДН АОНХС | | Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 3 удаа тодотгол -хийсэн. төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90 | Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийнэ.<br><br>Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90 | | | Ковид-19 халдварын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд 80 арга хэмжээг 90 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан. Цаг үеийн нөхцөл байдал Ковид-19 халдварын тархалттай холбоотойгоор 12 дахь удаагийн давтан үнэлгээ хийж, зөвлөмжийн дагуу төлөвлөгөөнд 1 удаа тодотгол хийсэн. Төлөвлөгөөний хүрээнд Ковид-19 халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт 3 дугаар тунд зорилтот насны иргэдийн 50.5 хувийг хамруулсан. Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэж, эмнэлгийн орны оновчтой зохион байгуулалтыг хийж ажилласнаар өвчлөл, хүндрэл, нас баралт 2021 онд 22 байсан бол 2022 онд нас баралт бүртгэгдээгүй байна. 11 дүгээр сарын байдлаар Ковид-19 халдварын тохиолдол 2476 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2130 тохиолдлоор буюу 53.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 1 удаа тодотгол хийсэн.<br>Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90 | 100 |
| 4. | 1.1.3. Мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах, албан хаагчдыг сургах, шаардлагатай тоног, төхөөрөмж, хамгаалалтын | 4. Мэргэжлийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна. | 2021-2024 | АОК | АОНХС | | Нийт 124.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.<br><br>ОНХСан | Дезкамер, цахилгаан автомакс, хамгаалах хувцсаар хангана. | | | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийг тус бүр 2ш улсын төсвийн 1.3 сая төгрөгийн 10 ширхэг цахилгаан автомаксаар хангасан. Коронавируст халдварын шинжилгээ хийж буй лабораториудыг бэхжүүлэх зорилгоор ДЭМБ-аас 52.3 сая төгрөгийн сорьц хадгалах хөргөгч, сорьц зөөвөрлөх аюулгүй сав, сорьц зөөвөрлөх гурвалсан хайрцаг болон Эрүүл мэндийн яамнаас 150.1 сая төгрөгийн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангасан. Мөн Хүнсний хясаа Мөөг ургуулах технологийн сургалтад нийт 20 хүн хамрагдаж, үүнээс | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | гийн 68.0 сая төгрөгөөр автомашин худалдаж авсан. | | | | 11 иргэн нэгдэн “Чойрын гурван богд” хоршоо байгуулан хүнсний зориулалттай хясаа мөөг тариалж, борлуулалтын каластерийг бий болгон, орон нутгийн хэрэгцээг хангахаас гадна Улаанбаатар хотруу бүтээгдэхүүнийг нийлүүлж байна. Орон нутгийн 59 сая төгрөгийн хөрөнгөөр Мэргэжлийн хяналтын лабораторт 22 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шийдвэрлэгдэх тоног төхөөрөмжийн тоогоор-10<br>Нийт зарцуулсан төсөв, хөрөнгө – 203.7 сая төгрөг | |
| 5. | | 5. Мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдыг сургаж чадавхжуулна. | 2021-2024 | АОК | БТ | | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо – 400; Сургалтын тоо - 28 | Мэргэжлийн байгууллагын албан хаагчдыг сургаж дадлагажуулна. | | | Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв болон лавлагаа шатлалаас зохион байгуулсан цахим болон танхимын 48 удаагийн сургалт зөвлөгөөнд давхардсан тоогоор 195 албан хаагч хамрагдсан. Төрийн болон хувийн хэвшлийн 9 эрүүл мэндийн байгууллагын 45 эмч, эмнэлгийн эмч, ажилтныг ажлын байранд нь чадавхжуулах дадлага сургалтыг зохион байгуулсан. “Коронавируст халдвар /Ковид-19/”-ын цар тахлын үеийн удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамж, цаашдын чиг хандлага”, “Коронавируст халдвар”-ын эсрэг Комирнэти вакцинаар 5-11 насны хүүхдийг вакцинжуулах ажлын хүрээнд эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад 6 албан хаагчийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтын тоо -48<br>Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо – 240 | 100 |
| 6. | 1.1.4. Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, сургууль, цэцэрлэгийн хүүхдийг томуугийн вакцинд хамруулна. | 6. Эрсдэлт бүлгийн хүн амыг улирлын томуугийн вакцинд хамруулна. | 2021-2024 | АЗДТГ, ЭМГ | УТХО | | Эрсдэлт бүлгийн 1468 хүн тун | Улирлын томуугийн вакцин 500 хүн тун | | | 2022 оны 10 дугаар сарын 20-30-ны өдрүүдэд ээлжит дархлаажуулалтын 10 хоногийг “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгууллаа. Улирлын томуугийн “GCFLU” дөрвөн цэнт вакциныг 4850 хүн тунг татан авч, эрсдэлт бүлгийн хүн ам болох 1-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, эрүүл мэндийн ажилчид, 65-аас дээш насныхан, архаг хууч өвчтэй нийт 2432 хүн тун дархлаажуулалтад хамруулж, дархлаажуулалтын ажил 50.1 хувьтай явагдаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Томуугийн вакцинд хамруулсан зорилтот бүлгийн хүний тоо-2432 | 100 |
| 7. | | 7. Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулна. | 2021-2024 | АЗДТГ, ЭМГ | УТХО | | 1-р тунгийн хамралт 93.2 хувь, 2-р тунгийн | Насанд хүрэгчдийг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд | | | 2022 онд Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын хамралт өссөн дүнгээр:<br>1-р тунгийн хамралт-90.6 хувь /12708 хүн/<br>2-р тунгийн хамралт 88.1 хувь /12086 хүн/<br>зорилтот 18-аас дээш насны нэмэлт 3-р тунгийн хамралт 50.5 хувь /5274 хүн/<br>4 -р тунгийн хамралт 4 хувьтай байна. /829 хүн/ | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамралт 94.2 хувь. 3-р тунгийн хамралт 43.6 хувь | хамруулна. | | | **Хүрсэн түвшин:**<br>Зорилтот бүлгийн хүн амын хамрагдалтын хувь-58.3 | |
| 8. | 1.1.5. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа сургалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. | 8. Хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлнэ. | 2021-2024 | АОК, ЭМГ | АОНХС | | Үндсэн эмчилгээний эмийн нөөц 7-10 хоног; шинж тэмдгийн эмчилгээний эмийн нөөц 20-45 хоног; ПГУ шинжилгээний оношлуурын нөөц 9-10 хоног; Түргэвчилсэн оношлуурын нөөц 40 хоног; Голомтын халдваргүйжүүлэлт хийх нөөц 30 хоног | Нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг сэлгэсэн байна. | | | 2022 онд эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг үнэлэхэд дунджаар: -Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 80.3 хувь<br>-Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн байх ёстой нөөцийг 2 сараар тооцоолон бүрдүүлэн ажиллаж 87.8 хувь<br>-Ковид-19 халдварын үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 91.7 хувьтай буюу дунджаар 55 хоногийн нөөцтэй байна. Улсын төсвөөс 150.1 сая төгрөгийн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслээр хангаж, эрүүл мэндийн байгууллагуудын Ковид-19 халдварын бэлэн байдлын үеийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг<br>**Хүрсэн түвшин:**<br>Эм эмнэлгийн хэрэгслийн нөөц 7-14 хоног<br>Хамгаалах хувцас хэрэгслийн нөөц дунджаар 20 хоног<br>Оношлуурын нөөц 15-20 хоног<br>Халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц 30 хоног | 100 |
| 9. | | 9. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | 2021-2024 | ЭМГ | БТ | | Цахим мэдээлэлд хандалт авсан иргэдийн тоо- | Шаардлагатай тохиолдолд гарын авлага тараах, цахим | | | Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх, вакцинжуулалт, дархлаа дэмжих, гэрийн нөхцөлд ариутгал халдваргүйжүүлэлт хийх заавар, зөвлөмж, мэдээ, мэдээллийг эрүүл мэндийн байгууллагын gsasurgaltsurtalchilgaa. Govisumber aimgiin ervvl mendiin gazar гэсэн цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр түгээн ажилласнаар 4600 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4000; Тараасан гарын авлага 18 төрлийн – 3200; Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо - 1320 | орчинд мэдээлэл бэлтгэж түгээнэ. | | | хүнд мэдээлэл хүргэсэн.<br>Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх 11 төрлийн 3000 гарын авлага, сургалт сурталчилгааны материалыг иргэдэд түгээсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалт мэдээллийн тоо-31<br>Мэдээлэл хүрсэн, сургалтад хамрагдсан иргэдийн тоо-7600 (Давхардсан тоогоор) | |
| 10. | 1.1.6. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 10. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АОК, АЗДТГ | БТ | | 2<br><br>5 | Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийнэ.<br><br>Үнэлгээнд үндэслэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | | | Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам батлах тухай” тушаалыг 86.0 хувийн хэрэгжилтийг хангаж, аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 5 сургууль, 6 цэцэрлэгийн орчны эрсдэлийг үнэлж, хамтарсан багуудыг ажиллуулсан.<br>Мөн 2022 оны 02 дугаар сарын 14-нөөс 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэл хугацаанд сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид, сурагчдаас түргэвчилсэн оношлуураар Ковид-19 өвчний шинжилгээг авч ажилласан. Шинжилгээнд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 42 багш ажилчид, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагч, цэцэрлэгийн 2-5 настай нийт 189 хүүхэд шинжилгээнд хамрагдсан. Тус шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдээс 7 хариу эерэг гарч, цаг алдалгүй арга хэмжээ авч ажилласнаар өвчнийг бусдад тархах нөхцөлийг бууруулсан.<br>Эрсдэлийн үнэлгээний дагуу зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, 8.07 хувийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 258 багш, ажилтнуудын 74 хувь буюу 192, цэцэрлэгийн 153 багш, ажилтны 93 хувь буюу 142 нь сүрьеэгийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж, 1 сэжигтэй тохиолдол илэрснийг хяналтад авч, эмчилгээнд хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эрсдэлийн үнэлгээ хийсэн тоо-2<br>Авч арга хэмжээний тоо-11<br>Түр журмын хэрэгжилт-86.0 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | | **97.9** |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| **Эрүүл мэнд** | | | | | | | | | | | | |
| **2.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | | | | | | |
| 11. | 2.1.1. Эрүүл мэндийн салбарыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | АОНХС | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 95.7 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/73 дугаар захирамжаар "Эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний хүрээнд 2 зорилтын 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 100 хувийн хэрэгжилтийг хангасан. Үүнд:<br>Орон нутгийн төсвийн 5.9 сая төгрөгөөр урвалж бодис, оношлуур худалдан авч элэгний В, С вирус илрүүлэх, БЗДХ/ДОХ, тэмбүү, сүрьеэ өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, 1160 иргэнийг хамруулаад байна.<br>Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 5 хоногийн хугацаатай хавдрын эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж нийт 689 иргэнд үзлэг хийж, 250 иргэнийг эсийн шинжилгээнд хамрууллаа.<br>Эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлж, дадлагажуулах, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, их дээд сургуулийн мэргэжлийн 5 багтай хамтарч ажиллаж байна. Тус ажлын хүрээнд орон нутагтаа гемодиализи эмчилгээ хийх бэлтгэл ажлын хүрээнд 1 их эмчийн сургасан. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэг, Улсын хоёрдугаар төв мэргэжлийн багийн хамтарсан сургалт, эмчилгээг орон нутагт зохион байгуулж, 35 эмч, ажилтныг ажлын байранд сургаж, дадлагажуулсан бол хүүхдийн анагаах ухаан, эх барихуйн тусламж, нийгмийн эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр нарийн мэргэжил эзэмших, мэргэжил дээшлүүлэх сургалтад 3 эмчийг хамруулсан.<br>Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэх, эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхижуулах, хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, боловсролыг дээшлүүлэх, дэмжих үйл ажиллагааг идэвхижүүлэх ажлын байрны сургалт.<br>Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарын мэдлэг, хандлага, чадварыг дээшлүүлэх, тасралтгүй суралцах үйл явцыг дэмжиж, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтран 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 6.8 сая төгрөгийг зарцуулж эмч, мэргэжилтнүүдийг чадавхижууллаа.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 100 | |
| 12. | 2.1.2. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2. Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг засварлаж, Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг эхлүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | УТХО<br>ТХ<br>АОНХС | | Халдвартын эмнэлгийн их засварын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэл – 100 хувь;<br><br>Эмнэлгийн ажилчдын байрны засварын зураг, төсөв боловсруулах ажлын гүйцэтгэл – 100 хувь | Халдвартын эмнэлгийн их засварын ажлыг хийнэ.<br><br>Эмнэлгийн ажилчдын байрны засварын ажлыг хийлгэнэ.<br><br>Эрүүл мэндийн газрын байрны их засварын ажлыг хийнэ. | | | Нэгдсэн эмнэлгийн барилгын үлдэгдэл санхүүжилт 1.300 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган батлуулан 2023 онд санхүүжилтийг шилжүүлнэ.<br>Халдвартын эмнэлгийн засварын ажлын зураг төсвийг хийлгэхээр тендер шалгаруулалтыг 2021 онд зарлаж, ММ архитектур ХХК-р 800.0 сая төгрөгийн өртөгтэй засварын ажлын зураг төсвийг хийлгэсэн. Мөн “Эрхэс констракшн” ХХК-тай гэрээ байгуулан нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн хуучин барилгыг ажилчдын байрны зориулалтаар засварлахаар зураг төсвийг боловсруулан, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар хянуулж байна. ОНХС-ийн 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр Эрүүл мэндийн газрын барилгын дээврийн болон дотор засвар, ХӨСҮТ-ийн 9.7 сая төгрөгийн санхүүжилтээр вакцины өрөөний засварыг тус тус хийж гүйцэтгэсэн. Эрүүл мэндийн газрын урсгал засварын ажлын 32.0 сая төгрөгийн тендерийг зарласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Халдвартын эмнэлгийн их засварын ажлын зураг, төсөв хийгдсэн.<br>Эмнэлгийн ажилчдын байрны засварын зураг төсвийн магадлалаар хянагдаж байна.<br>Эрүүл мэндийн газрын байрны дээврийн болон дотор заслын ажлыг бүрэн хийсэн. | 90.0 |
| 13. | | 3. Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 2021-2024 | АЗДТГ | УТХО | | Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн тоо - 42<br>Төсөвт өртөг – 501.6 сая төгрөг | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана. | | 1,269.6 сая төгрөг | Орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгөөр “Мехатроник” ХХК–тай гэрээ байгуулан аймгийн Нэгдсэн эмнэлгийг 5 төрлийн тоног төхөөрөмж (мэс заслын вакум өрөөнд таазны гэрэл, автомат гар угаагч тосгуур, төрөх тасагт ургийн монитор, хагас автомат төрөх ор, шүдний кабинетад шүдний иж бүрэн үзлэгийн ор)–өөр хангасан.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 963.0 сая санхүүжилтээр “Эрүүл мэндийг дэмжих” төвийг рентген харалтын аппарат, хэвлийн болон зүрхний ЭХО аппарат, чих хамар хоолойн үзлэгийн иж бүрдэл зэрэг | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | АОНХС | | | | | | багаж, тоног төхөөрөмжөөр хангасан.<br>Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийг сайжруулах зорилгоор 9.1 сая төгрөгийн зөөврийн компьютер, ДЭМБ-ийн 2.2 сая төгрөгийн суурин компьютер нийлүүлсэн.<br>2022 онд аймгийн Эрүүл мэндийн газар 4.5 сая төгрөгийн 2 тоног төхөөрөмж, Нэгдсэн эмнэлэг 1,212.7 сая төгрөгийн 47, Шивээговь ЭМТөв 37.4 сая төгрөгийн 21, Баянтал сумын ЭМТөв 15 сая төгрөгийн 6 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хангагдсан техник, тоног төхөөрөмжийн тоо - 76<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ – 1,269.6 сая төгрөг | |
| 14. | | 4. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээг үзүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | - | | Хорт хавдрын уламжлалт хими эмчилгээг хийж эхлэх нөхцөлийг бүрдүүлсэн. | Эрэгтэйчүүд судлал, гэмтэл, дотоод шүүрлийн эмчилгээг хийж эхэлнэ. | | | 2021-2022 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, орон нутгийн жишиг эмнэлэг болгох зорилтыг тавин тусламж, үйлчилгээний тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Тус ажлын хүрээнд урологи, эрэгтэйчүүд судлал, гэмтэл, химийн эмчилгээ зэрэг 4 төрлийн тусламж, үйлчилгээг шинээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, дээрх чиглэлээр тус бүр их эмчийг сургаж, мэргэшүүлсэн.<br>Мөн Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр хими эмчилгээний 7 хоногийн дадлага, сургалтыг ажлын байранд нь зохион байгуулсан.<br>Цээж, хэвлийн хавсарсан гэмтэл, үений гэмтэл чиглэлээр 2 эмч бэлтгэгдэж, шилбэний гэмтлийн хадаас суулгах мэс заслын эмчилгээг эхлүүлэх багажтай болсон. Тайлант онд гэмтлийн мөчдийн хагалгааг шинээр нэвтрүүлж, 3 тохиолдолд хадаас авах мэс ажилбар хийгдсэн байна.<br>Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн тасагт мэс заслын дараах өвдөлт намдаах болон гэдэсний саажилтын эсрэг эмчилгээнд нугасны гадна хөндийд гуурс байрлуулан эмчилгээнд хэрэглэж эхэлсэн.<br>Гемодиализын тусламж үйлчилгээг үзүүлэх бэлтгэл ажлын хүрээнд УТХО-аар аппараттай болсон эмч, сувилагч, техникч бэлтгэгдсэн 2023 оноос орон нутагтаа эмчилгээг хийж эхэлнэ<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний тоо- 4 | 100 |
| 15. | | 5. Яаралтай | 2021- | ЭМГ | УТХ | | Анхан | Аймгийн | | | Эрүүл мэндийн яамнаас улсын төсвийн 155.0 сая | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тусламж үйлчилгээний хүртээмж чадавхыг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ. | 2024 | | О | | шатны эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. | Нэгдсэн эмнэлгийг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр хангана. | | | төгрөгөөр аймгуудын Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн автомашинаар хангахаар батламж гардуулсан бөгөөд Эрүүл мэндийн сайд орон нутагт ирж автомашиныг гардуулж, 11 дүгээр сард автомашиныг хүлээн авч, тусламж үйлчилгээнд ашиглаж байна.<br>Улсын төсвийн 3.8 сая төгрөгөөр Өрхийн эрүүл мэндийн төвийн яаралтай үед үзүүлэх тусламж үйлчилгээнд зориулж хүчилтөрөгч аппарат, хяналтын монитор, яаралтай тусламжийн иж бүрдлээр тус тус хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн тоо-7<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ-3.8сая төгрөг. | |
| 16. | | 6. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулна. | 2021-2024 | ЭМГ | АОНХС | | Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь 80.2;<br><br>Сүрьеэ өвчлөлийн түвшин – 6,7;<br><br>Тэмбүү өвчний түвшин – 1,1 ; | Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь 60.0<br><br>Сүрьеэ өвчлөлийн түвшин - 13.5<br><br>Тэмбүү өвчний түвшин - 24.0 | | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/128 дугаар захирамжаар хавдрын эрт илрүүлгийг 2022 оны 05 сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна.<br>Хавдрын эрт илрүүлэг үзлэгийн дундаж хамрагдалт 76.0 хувьтай байна.<br>Хөхний хорт хавдрын эрт илүүлэг үзлэг шинжилгээнд 30-60 насны 3458 эмэгтэйчүүд хамрагдахаас 3458 хамрагдаж 100 хувьтай, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1241 эмэгтэй хамрагдахаас 331 хамрагдаж 26.6 хувьтай, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 4429 иргэн хамрагдахаас 2500 иргэн хамрагдаж 56.4 хувьтай байна.<br>Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг ХӨСҮТөвтэй хамтран зохион байгуулж, нийт 689 иргэнийг үзлэгт хамруулан хортой хавдар 1, хортой гэж сэжиглэгдсэн 5, хоргүй хавдар 30, хавдрын урьдал өвчин 22, хяналтын үзлэг 37, бусад өвчлөл 304 бүртгэгдсэн.<br>Халдварт өвчний 2619 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчин 10000 хүн амд 1440.4 буюу улс, аймгийн дунджаас өндөр үзүүлэлттэй байна. Ковид-19 халдвар 2517 буюу нийт халдварт өвчний 96.1 хувийг эзэлж байна.<br>Сүрьеэ өвчний 15 шинэ тохиолдол бүртгэгдэн 10 000 хүн амд 8.3 байгаа нь аймгийн дунджаас 2.8 хувиар их, улсын дундажаас 1.4 проммиллээр их байна.<br>Тэмбүү өвчний 16 шинэ тохиолдол бүртгэгдэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 тохиолдлоор нэмэгдсэн боловч 10000 хүн амд 8.8 байгаа нь аймгийн дунджаас 0.7 их, улсын дунджаас харьцуулаха д 3.4 промиллээр бага байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь-76.0<br>Сүрьеэ өвчлөлийн түвшин 8.3 | 52.3 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Тэмбүү өвчний түвшин 8.8 | |
| 17. | 2.1.4. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 7. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | УТХО | | Мобайл технологи нэвтрүүлсэн ЭМБ -3 | Сүмбэр сумын Өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи нэвтрүүлнэ. | | | ДЭМБ-ын хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын эрүүл мэндийн төвд 2018 онд, Баянтал, Сүмбэр сумын Өрхийн эрүүл мэндийн төвд 2021 онд Мобайл технологийг бүрэн нэвтрүүлж, тоног төхөөрөмжөөр хангаж, алслагдсан баг, өрхийн хүн амд тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>Эхний 5 сарын байдлаар өрхийн эрүүл мэндийн төвөөс “ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН” аяны хүрээнд Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газрын нийт 341 /давхардсан тоогоор/ алба хаагч, хөдөөгийн 3 багийн 89 иргэнд тусламж үзүүлсэн.<br>Шивээговь сумын эрүүл мэндийн төвд 48, Баянтал сумын эрүүл мэндийн төв амбулаториор үйлчлүүлсэн 8 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байна.<br>Мобайл технологийн түргэвчилсэн оношлуураар нийт 4452 иргэнд шинжилгээ хийгджээ. Үүнийг задалж авч үзвэл:<br>•HIV – 1346 иргэн<br>•ТРНА – 1744 иргэн /182 иргэн эерэг/<br>•Хелекобактер -192 иргэн<br>•В вирус – 681 иргэн /17 иргэн эерэг/<br>•С вирус – 681 иргэн /11 иргэн эерэг/<br>•Сахар-192 /17 иргэн эерэг/<br>•Холестрин-192 иргэнд тус тус шинжилгээ хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Мобайл технологийн цахим үйлчилгээнд ирсэн дуудлага, бүртгэлийн тоо-4938<br>Шийдвэрлэлтийн хувь-100 | 100 |
| 18. | | 8. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | УТХО | | Эм зүйн албыг байгуулах ажлыг эхлүүлсэн.<br><br>Эмийн чанар, аюулгүй байдлын програм хангамж бүрэн нэвтэрсэ | Эмийн чанар аюулгүй байдлын программ хангамжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.<br><br>Эм зүйн албаны үйл ажиллагаа тогтмолжуулна. | | | Эрүүл мэндийн байгууллагуудад цахим жор бичих эрх бүхий 33 эмч (Нэгдсэн эмнэлэгт 24, Шивээговь сумын эрүүл мэндийн төвд 2, Баянтал сумын эрүүл мэндийн төвд-1, “Энхтусдэм” Өрхийн эрүүл мэндийн төвд 6) ажиллаж байна.<br>2022 онд нийтийн үйлчилгээтэй 8 эмийн санд давхардсан тоогоор 16123 иргэн цахим жороор үйлчлүүлсэн.<br>Цахим жорыг нэвтрүүлсэн эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тоо 1-ээр нэмэгдэж, 12 болсон.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эм зүйн алба, эмнэлгийн эмийн сангийн өрөө тасалгааг стандартын дагуу зохион байгуулж, 1 эм зүйч, 1 эм найруулагчтайгаар ажиллаж байна.<br>Эм зүйн албанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны удирдамжийн дагуу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг” | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | н | | | | хангуулахаар Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Ажил олгогч эздийн холбоо, Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран 1 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь хангуулан ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Байгуулагдсан албаны тоо-1<br>Хяналт шалгалтын тоо-1<br>Эм зүйн албаны үйл ажиллагаа тогтмолжсон.<br>Эмийн чанар аюулгүй байдлын программ хангамжийг нэвтрүүлсэн. | |
| 19. | 2.1.5. Жирэмсний хяналтыг сайжруулах замаар эхийн хүндрэлийг бууруулж, сэргийлж болох нялхсын эндэгдлийг багасгана. | 9. Жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлж, хүүхдийн эндэгдлийг бууруулна. | 2021-2024 | ЭМГ | СО НХ С | | Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь – 92.5<br>Нялхсын эндэгдэлийн түвшин - 2.1<br>1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин – 0 | Жирэмсний хяналт -87.9 хувь<br><br>Нялхсын эндэгдлийн түвшин -7.0<br><br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин - 11.0 | | | Аймгийн хэмжээнд 2022 онд 380 эх төрж, 378 хүүхэд мэндэлсэн. Амьгүй төрөлт 3 бүртгэгдсэн.<br>Нийт 340 жирэмсэн эхийг хяналтад авснаас эхний 3 сартай хяналтад 306 жирэмсэн эх хамрагдаж, эрт үеийн хяналт 90.0 хувьтай байна.<br>Нялхсын эндэгдэл 4 буюу 1000 амьд төрөлтөд 10.5 промиль байна.<br>1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 2.6 промиль байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь – 90.0<br>Нялхсын эндэгдлийн түвшин -10.5<br>1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин – 2.6 | 61.8 |
| 20. | 2.1.6. Хүний хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 10. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжин хөгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | АО НХ С | | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь - 90.0<br>Сургалтад | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь<br><br>Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургаж, | | | Эрүүл мэндийн салбарын “Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгаа хангах” хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт 16 арга хэмжээг төлөвлөн, 93.3 хувьтай хэрэгжүүлсэн. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил эзэмших, мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 13 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулсан. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудаас зохион байгуулсан цахим болон танхимын 48 удаагийн сургалт зөвлөгөөнд давхардсан тоогоор 170 албан хаагчийг хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагууд 14 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 937 албан хаагчийг ажлын байрны сургалтад хамруулан чадавхжуулсан. МЭИК-иас 723.0 мянган төгрөгийн дархлаажуулалтын | 93.3 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны тоо -30<br>Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны тоо -10<br>Нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээний тоо -3<br>Байр орон сууц, байраар хангагдсан эмч, эмнэлгийн ажилтны тоо -13<br>Зарцуулсан төсөв -20.0 сая төгрөг. | чадавхжуулна<br><br>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулна<br><br>Ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | | | амин дэмээр 17 албан хаагчийг хангасан. Эрүүл мэндийн газрын 16 албан хаагчийг Эх хүүхэд, эмэгтэйчүүдийн үндэсний төвд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулж, 8 албан хаагчийг эрүүл мэндийн даатгал болон хамтын сангийн хөнгөлөлтөөр Хужирт рашаан сувилалд эмчилгээнд хамруулсан. Эмч, сувилагч, тусгай мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, тусламж үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, байгууллагын соёл, уур амьсгалыг сайжруулах зорилгоор “Хүндэтгэлтэй харилцаа-Чанартай үйлчилгээ” 9 сарын аяныг зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр нийт 62 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 1109 эмч, мэргэжилтэн, эмнэлгийн ажилтныг хамруулсан. Эрүүл мэндийн салбарын 128 албан хаагчдад 708.0 сая төгрөгийн илүү цаг, 190 албан хаагчдад 192.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 191 албан хаагчдад 126.0 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгосон. 7 их эмчийг түр орон сууцаар, 5 их эмч, 2 сувилагч, тусгай мэргэжилтэнг албаны байранд байрлуулж, түрээсийн байрны дэмжлэгт 10 эмч, мэргэжилтнийг хамруулж, АОНХС-аас 5 албан хаагчид 6.7 сая, аймгийн Нэгдсэн эмнэлэг өөрийн орлогоос 5 албан хаагчид байрны урьдчилгаа тус бүр 10.0 сая, нийт 50.0 сая төгрөг олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 93.3 хувь<br>Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургаж, чадавхжуулж, сургалтад хамрагдсан эмч, ажилтны эзлэх хувь – 90<br>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулна<br>Ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх 1 арга хэмжээ зохион байгуулсан. | |
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | | **89.7** |
| **Биеийн тамир, спорт** | | | | | | | | | | | | |
| **2.2. Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | |
| 21. | 2.2.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга | 1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг | 2021-2024 | АЗДТГ | АОНХС | 230.0 | Арга хэмжээний | Арга хэмжээний төлөвлөгөөн | | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/73 дугаар захирамжаар “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх” арга хэмжээний хүрээнд 4 зорилтын 13 арга хэмжээг 100 | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг хэрэгжүүлнэ. | хэрэгжүүлнэ. | | | | | төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | ий хэрэгжилтийн хувь-100 | | | хувьтай хэрэгжүүлсэн. Үүнд: “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг зохион байгуулж 8756 иргэн, “Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил” болзолт уралдаанд 300 хүүхэд, Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны арга хэмжээг спортын 14 төрлөөр зохион байгуулж 1830 тамирчин, бүсийн тэмцээнд спортын 3 төрлөөр 72 тамирчин, Говьсүмбэр аймгийн арслан Л.Азжаргалын нэрэмжит “Жүдо бөхийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн”-д 84 тамирчин, Монголын бүх ард түмний спортын XV наадмын волейболын бүсийн тэмцээнд 24 тамирчин, ширээний теннисний өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 28 тамирчин тус тус оролцсон. Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд Говьсүмбэр аймгийн "Говийн усчид' клубийн баг тамирчид оролцож 3 алт, 9 мөнгө, 15 хүрэл нийт 27 медаль хүртсэн. Монголын бүх ард түмний XV дугаар наадмын шигшээ тэмцээнд спортын 7 төрлөөр 130 тамирчин оролцож, 2 алт, 3 мөнгө, 5 хүрэл нийт 10 медаль хүртэж, багийн дүнгээр 12 дугаар байранд, Үндэсний сурын “Говийн бүсийн чуулга” холимог багийн харвааг орон нутагт зохион байгуулж, 5 аймгийн 10 баг оролцож, Говьсүмбэр аймгийн баг, тамирчид 3 дугаар байранд тус тус шалгарсан. Зүүн аймгуудын Биеийн тамир, спортын газруудын хүрээнд “Хамтдаа хөгжье” сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 121 албан хаагчийг хамруулсан. “НӨХӨРЛӨЛ - 2022” спортын 3 төрөлт анхдугаар бага наадам зохион байгуулж, Говьсүмбэр аймагт 1988-оноос 2021 онд суралцаж төгссөн 31 төгсөлтийн 1300 гаруй иргэнийг хамруулсан. Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Л.Цэдэнсодномын нэрэмжит Волейболын нээлттэй тэмцээнийг зохион байгуулагдаж, нийт 26 баг 234 тамирчид оролцсон. Тус арга хэмжээний хүрээнд спортын 15 төрлийн 60 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд, 1200 тамирчин оролцож, нийт 37 алт, 43 мөнгө, 60 хүрэл медаль хүртсэн.<br>**Хүрсэн түвшин**:<br>Арга хэмжээний тоо-13<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | |
| 22. | 2.2.3. Усан бассейн бүхий спорт цогцолбор барина. | 3. Усан бассейн бүхий спорт цогцолбор барина. | 2021-2024 | АЗДТГ | УТХО | 7,122.0 | Зураг төсөв хийгдсэн. | Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | 3,000.0 | | 2022 оны Улсын төсөвт 13.0 тэрбум төгрөгийн хөрөнгө тусгагдсан боловч Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилтийг эргүүлэн татсан. | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23. | 2.2.4. Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборын барилга барина. | 4. Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборыг барина. | 2021-2024 | АЗДТГ | УТХО | 5,035.0 | Зураг төсөв хийгдсэн. | Баянтал сумын Соёл, спортын цогцолборын барилгын ажлыг эхлүүлнэ.<br><br>Шивээговь сумын Соёлын төвийн барилгын төсвийг шинэчилнэ | 1.500.0 | | Баянтал сумын Соёл, спортын цогцолборын барилгын зураг төслийг боловсруулах ажлыг “Ориент плюс” ХХК гүйцэтгэж, холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж байна.<br>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор зураг төсвийн ажлын төсөв шинэчлүүлэхээр 20,000,000 төгрөгийг батлуулсан. Дээрх төсөвт Шивээговь сумын Соёлын төвийн барилгын төсвийг шинэчлүүлэхээр ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Баянтал сумын Соёл, спортын цогцолборын барилгын зураг, төсвийг боловсруулсан.<br>Шивээговь сумын Соёлын төвийн барилгын төсвийг шинэчлүүлэх ажил хийгдэж байна. | 30 |
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | **53.3** |
| **Боловсрол** | | | | | | | | | | | |
| **2.3. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | | | | |
| 24. | 2.3.1. Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | АОНХС | 150.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-95 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | 35.0 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/73 дугаар захирамжаар Боловсролыг дэмжих 12 арга төлөвлөн 90.0 хувьтай хэрэгжүүлсэн.Үүнд: Багш нарын ур чадварыг дээшлүүлэх 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 163 багшийг хамруулсан. Нийслэлийн ерөнхий боловсролын 52, 75 дугаар сургууль, 16, 147 дугаар цэцэрлэг, Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын 2, 5 дугаар сургууль, 4, 8 дугаар цэцэрлэгүүдтэй хамтран 28 удирдах ажилтан, багш нарыг туршлага судлуулсан. 10 багшийн байрны түрээсийг шийдвэрлэж, 10.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон. “Элсэлтийн нэгдсэн шалгалт”-ын бэлтгэх сорилгыг 10 хичээлээр зохион байгуулж, 1046 даалгаварт шинжилгээ хийж, зөвлөмж өгч ажилласны дүнд 2022 оны “Элсэлтийн нэгдсэн шалгалт”-ын дундаж оноо өмнөх оноос 8 функтээр нэмэгдэж 528 болж, 7 хичээлээр улсын дундаж онооноос дээш дүнтэй амжилт үзүүлсэн. Малчдад бичиг үсгийн боловсрол олгох, угийн бичиг хөтлөхөд зориулж “Малчин өрхийн бодит туршлага” цуврал нэвтрүүлэг, 4 удаагийн контентыг Сүмбэр сумын 60 өрхийг оролцуулан бэлтгэж, орон нутгийн телевиз, олон нийтийн цахим сүлжээгээр 1720 иргэнд хүргэсэн. Монгол Улсын Гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит монгол бичгийн 19 дүгээр олимпиадыг зохион байгуулж, 51 төрийн байгууллага, 528 албан хаагч, 34 багш, 226 сурагч, 41 иргэн хамрагдсан. Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэлтэй | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хамтран “Орос хэлний бүсийн олимпиад, соёлын арга хэмжээ” зохион байгуулж, 5 аймгийн 80 сурагч, 20 багш хамрагдаж, 2 сурагч, 1 багш ОХУ-ын их дээд сургуульд үнэ төлбөргүй суралцах “Эрхийн бичиг”-ээр шагнагдсан. Боловсролын байгууллагуудын дунд спортын наадмыг зохион байгуулж, 250 багш хамрагдсан. хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 5 сургуулийг арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. Аймгийн тэргүүний сургууль, цэцэрлэгээр Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг, 3 дугаар сургуулийг шалгаруулан урамшуулсан. Арга хэмжээний хүрээнд нийт 8 удаагийн сургалт, 11 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 220 багш, ажилчид, 2990 сурагчдыг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний хэрэгжилтийн хувь-90 | |
| 25. | 2.3.2. Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулна. | 2. Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулна. | 2021-2024 | АЗДТГ | УТХО | 3,250.0 | Сургуулийн барилгыг ажлын гүйцэтгэл 25 хувь | Сургуулийн барилгыг ажлын гүйцэтгэл 100 хувь | 1.500.0 | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг Говийн өгөөж ХХК –тай гэрээ байгуулан суурин ажлууд хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна. Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Моннич кон Трейд” ХХК шалгарч, гадна инженерийн шугам сүлжээ, цахилгааны ажлуудыг гүйцэтгэсэн бөгөөд тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувь байна. Барилгын ажлын гүйцэтгэл 35 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургуулийн барилгыг ажлын гүйцэтгэл 30 хувь | 30 |
| 26. | 2.3.3. Сүмбэр сумын 5 болон 1 дүгээр сургуулийн барилгыг 320 хүүхдийн барилгаар өргөтгөнө. | 4. Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулна. | 2021-2024 | АЗДТГ | УТХО | 3,535.0 | Зураг төсвийн ажил хийгдсэн. | Барилгын ажлыг эхлүүлнэ. | 1,500.0 | | Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 320 хүүхдийн барилгын өргөтгөлийн ажлыг 2023 оны төсөвт тусгуулахаар саналыг Сангийн яамны цахим системээр хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>2023 оны улсын төсөвт шаардагдах төсвийг батлуулахаар баримт бичгийг хугацаанд хүргүүлсэн. | 30 |
| 27. | 2.3.4. “Чадварлаг багш” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, | 5. “Чадварлаг багш” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн бүтээмжид | 2021-2024 | АЗДТГ | ОНТ | 80.0 | 74<br><br>6 | Урамшуулах багшийн тоо – 20<br><br>Дэмжлэг үзүүлэх | 20.0 | 16.1 | “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд сурагчдын сурлагын чанарын ахиц, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, шилдэг хөтөлбөр арга зүйгээр үр дүн, амжилт гарган ажилласан 66 багшийг 16.1 сая төгрөгөөр урамшуулсан.<br>Мөн орон нутагт нэн шаардлагатай мэргэжлийн 8 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана. | суурилсан үнэлэмжийг бодитой болгоно. | | | АОНХС | | 40<br>520 | багшийн тоо – 5<br>Боловсролын чанарын үнэлгээ -39 хувь<br>Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 512 | 10.0<br>2.0<br>35.0 | 10.0<br>-<br>29.2 | багшийн байрны түрээсийг шийдвэрлэж, 10.0 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.<br>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтанд үр дүнгийн үнэлгээ хийх зорилгоор Аймгийн Засаг даргын нэрэмжит чанарын үнэлгээний шалгалтыг 3-11 дүгээр ангиудын 3258 суралцагчийг хамруулан 19 шалгалт авсан. Үнэлгээний шинжээч нар 19 шалгалтын 570 даалгаварт шинжилгээ хийж, даалгаврын хүнд хөнгөний зэрэг ялгах чадварыг боловсруулж, зөвлөмж бичиж, сургуулиудад хүргэсэн. Шалгалтанд хамрагдсан судлагдахууны нийт 120 багш нарт танхимаар дүнгийн хурал зохион байгуулж, зөвлөгөө зөвлөмж, цаашид сурлагын амжилтыг ахиулах хэлэлцүүлэг өрнүүллээ.<br>Элсэлтийн нэгдсэн шалгалтад бэлтгэх “Сорилго шалгалт”-ыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1046 сурагчийг хамруулсан бөгөөд 2022 оны Элсэлтийн нэгдсэн шалгалтын дүнгээр 7 хичээл (монголын түүх, нийгмийн тухай мэдлэг, орос хэл, хими, биологи, монгол хэл, газарзүй) улсын дунджаас дээгүүр, аймгийн дундаж оноо 528 байгаа нь 2021 онтой харьцуулахад 8 оноогоор дээшилсэн.<br>Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дунд “Хүүхэд бүрийн ялгаатай хөгжил” сэдэвт математикийн энгийн төсөөлөл хичээлээр уралдаан зохион байгуулж, 7 багш оролцсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Урамшуулах багшийн тоо-66<br>Дэмжлэг үзүүлсэн багшийн тоо - 8<br>Боловсролын чанарын үнэлгээ –72.1<br>Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо-528 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28. | | 6. Цахим зайн сургалтын платформыг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ. | 2021-2024 | БСУГ | АОНХС | - | 1108 /давхардсан тоогоор / | Цахим хэлбэрээр мэргэжлийн болон ур чадвар, ёс зүйн сургалтад хамрагдсан багшийн тоо-150 | 3.0 | 1.4 | Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын мэдээллийн технологийн төвтэй хамтран “Цахим контент бүтээх“ сургалтыг зохион байгуулж, 5 сургуулийн 81 багш, 5 сургалтын менежер хамрагдаж, “medle.mn” Үндэсний виртуал сургуульд цахим хичээлээ байршуулах арга зүйд суралцаж, бага ангийн бэлтгэл бүлэг, дунд ангийн “Эрүүл мэндийн хичээл”-ийн цахим контент оруулах эрх авч, ажлаа эхлүүлээд байна.<br>Ээлжит хичээлийн 7 нэгжийн 35 хичээлийг “medle.mn” Үндэсний виртуал сургуульд байршуулсан.<br>Англи хэлний хичээлээр тусгайлан бэлтгэсэн 2 өдрийн 12 цагийн цахим сургалтыг зохион байгуулж, 18 багшийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо-19<br>Сургалтад хамрагдсан багшийн тоо-733 | 100 |
| **3.1. Санхүү, эдийн засгийн нээлттэй, ил тод байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | |
| 60. | 3.1.1. Цахим татварын системийг нэвтрүүлэн иргэд татварын үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжийг хангах замаар татварын баазыг нэмэгдүүлнэ. | 1. Цахим татварын системийг нэвтрүүлж, татвар төлөгчдөд татварын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэн, иргэдэд сурталчилна. | 2021-2024 | Татварын хэлтэс | УТ | 5.0 | Цахим татварын систем 70 хувь нэвтэрсэн байна | Цахим татварын систем 100 хувь нэвтэрсэн байна | | | Цахим татварын системийг 100 хувь нэвтрүүлсэн бөгөөд цахим системд аймгийн хэмжээнд татвар төлөгч 698 аж ахуйн нэгж, 386 иргэн бүртгэгдэж, 100 хувь ашиглаж байна.<br>Аймгийн ЗДТГ болон төрийн цахим үйлчилгээний И-Монголиа систем хөгжүүлэгчдийн хамтарсан өдөрлөгт Татварын хэлтэс оролцож 47 нэр төрлийн цахим үйлчилгээний талаар 2377 иргэнд мэдээлэл, заавар, зөвлөмж өгч ажилласнаар 115 иргэн 9.8 сая төгрөгийн татвар төлсөн.<br>Малын тоо толгойн албан татварын ажлын хүрээнд Татварын хэлтэс нь цахим хуудсаараа дамжуулан /live/ сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 25000 иргэнд мэдээлэл хүрсэн. Тус сургалтаар малын тоо толгойн албан татварын тайланг цахимаар илгээх, нэхэмжлэхээ хэрхэн үүсгэн татвараа төлөх талаар мэдээлэл өгч ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахим татварын системийн ашиглалтын хувь-100 хувь | 100 |
| 61. | | 2. Татварын бааз суурийг 2020 оны суурь түвшингээс жил бүр 0.5-аас хувиар нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Татварын хэлтэс | УТ | | Хуулийн этгээдийн тоо - 642 | Хуулийн этгээдийн тоо - 687 | | | 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд 656 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2022 онд 698 болж, 2021 онтой харьцуулахад 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 153.3 хувьтай байна.<br>Орон нутгийн орлогын төлөвлөгөө 9 082.4 сая.төгрөг, гүйцэтгэл 9 444.9 сая.төгрөг буюу 104.0 хувийн биелэлттэй байна.<br>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Балдандзасаг захын худалдаа эрхлэгч 67 иргэнд дээрх хууль болон QR код олгох, баталгаажуулах чиглэлээр сургалт зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хуулийн этгээдийн тоо: 698 | 100 |
| 62. | 3.1.2. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг | 3. Төрийн албаны цалингийн нэгдсэн системд төрийн байгууллагуудыг хамруулж, гүйлгээг шуурхай гүйцэтгэнэ. | 2021-2024 | АЗДТГ | БТ | | Хамрагдах байгууллагын тоо - 53 | Хамрагдах байгууллагын тоо - 54 | | | Төрийн албаны цалингийн нэгдсэн системд нийт 56 байгууллагыг бүрэн хамруулж, төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээ хэвийн явагдаж байна.<br>Тагнуулын тасаг, Онцгой байдлын газар гэсэн 2 байгууллагыг нууцын зэрэглэлтэй гэдэг үндэслэлээр тус системд оруулахгүй байхаар Сангийн яамнаас чиглэл өгсний дагуу хамруулаагүй. Төрийн | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шуурхай болгон, төсвийн урсгал болон гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр төрийн сангийн цахимжуулалтыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үүднээс” Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг ашиглан цахимаар баталгаажуулах, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний дугаар 190 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын талаар тус тус сургалт зохион байгуулж, 42 байгууллагын 58 албан хаагчийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамрагдсан байгууллагын тоо – 56 | |
| 63. | | 4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээ оруулалтад тогтмол хяналт тавина. | 2021-2024 | СХАА | БТ | | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо –25<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь–96.7<br><br>Тайлан илгээлтийн хувь -100 | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо –81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь–93<br><br>Тайлан илгээлтийн хувь -100 | | | Санхүүгийн хяналт, аудитын алба сар бүрийн 20-25-ны өдрийн хооронд шилэнд дансанд мэдээлэл оруулах нийт 75 байгууллагын мэдээлэлд хяналт тавин ажиллаж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 97.9 хувь байна. Өмнөх оны мөн үеэс 3 хувиар өсчээ. 4-р улирлын байдлаар тайлан илгээлт 100 хувь.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо-75<br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь 97.9<br>Тайлан илгээлтийн хувь-100<br>Хэрэгжилтийн хувь-100 | 99.3 |
| 64. | | 5. Төсвийн зарцуулалтын үр ашиг, хяналтыг сайжруулна. | 2021-2024 | СХАА | БТ | | Хяналт шалгалтын тоо-16<br><br>Зөрчлийн дүн өмнөх онтой харьцуулахад 25 хувиар буурсан байна. | Хяналт шалгалтын тоо-21<br><br>Зөрчлийн дүн өмнөх онтой харьцуулахад 30 хувиар буурсан байна. | | | Тайлант хугацаанд санхүүгийн аудит 12, гүйцэтгэлийн аудит 11, шилэн дансны нийцлийн аудит 36 нийт 59 хяналт шалгалт төлөвлөснөөс 59 хяналт шалгалт хийсэн. Мөн иргэнээс ирүүлсэн өргөдлийг үндэслэн 1, Сангийн яамны нэгдсэн удирдамжаар 4 хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 1 402.5 сая.төгрөгийн зөрчил илрүүлснээс 14.1 сая.төгрөгийг орон нутгийн орлого болгохоор, 1.6 сая.төгрөгийг хувь хүнд буцаан олгохоор, 0.9 сая.төгрөгийг санд буцаан төвлөрүүлэхээр, 0.9 сая.төгрөгийг улсын орлого болгохоор акт тогтоосон. Актын барагдуулалт 70 хувьтай байна. Мөн 493.6 сая.төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн ба биелэлт тооцох хугацаа болоогүй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хяналт шалгалтын тоо-59 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Зөрчлийн дүн өмнөх онтой харьцуулахад 56.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 65. | 3.1.3. Орон нутагт эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжиж ажиллана. | 6. Орон нутагт эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг газар, дэд бүтэц, зээлийн бодлогоор дэмжинэ. | 2021-2024 | СЗДТГ, ХХААГ | СХС, ЖДҮДС | | Тэргүүлэх салбарын бизнес эрхлэгчдийг газар, дэд бүтэц, зээлийн бодлогоор дэмжинэ. | Тэргүүлэх салбарын бизнес эрхлэгчдийг газар, дэд бүтэц, зээлийн бодлогоор дэмжинэ. | | | Жижиг дунд, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлэх аймгийн тэргүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/115 дугаар захирамжаар баталсан.<br>2022 онд “Язгуур баялаг” нэхий элдэх, боловсруулах, Оорцог элгэн хоршоо зоорь, агуулах, Чойрын гурван богд хоршоо мөөг, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр нийт ЖДҮХСангаас 300.0 сая төгрөг, Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас Барилгын материалын туслах төмөр хийц, бүтээц, бусад төмөр хийцийн “Арвижих” үйлдвэрийн төсөлд 70.0 сая төгрөг, Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сангаас мах махан бүтээгдэхүүн, болон дайвар бүтээгдэхүүн бэлтгэх чиглэлээр “Оорцог” үйлдвэрийн төсөлд 85.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгон дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дэмжлэг олгосон зээлийн тоо 5, олгосон зээлийн 455.0 сая төгрөг | 100 |
| 66. | 3.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг бүрэн цахимжуулна. | 7. Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлуудын бараа материалыг дотоодоос худалдан авах боломж нөхцөлийг бүрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана. | 2021-2024 | ОНӨГ, СЗДТГ | БТ | | Барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтад 100 хувь дотоодын давуу эрх олгох талаар тусгасан байна. | Барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтад 100 хувь дотоодын давуу эрх олгох талаар тусгасан байна. | | | 2022 онд төрийн болон орон нутгийн хөрөнгөөр 18,018.19 сая.төгрөгийн төсөвт өртөг бүхий 75 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарласан ба тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгох нөхцөлийг 100 хувь тусгасан.<br>Үүнээс худалдан авах ажиллагаанд оролцсон 4 аж ахуйн нэгж 85.0 сая төгрөгийн ажиллах хүч, бараа материалын дотоодын давуу эрх тооцуулж тендерт шалгарсан байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дотоодын давуу эрх олгосон тендерийн хувь-100<br>Дотоодын давуу эрх тооцуулан гэрээ байгуулсан тендерийн тоо - 4 | 100 |
| 67. | | 8. Тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулна. | 2021-2024 | ОНӨГ, СЗДТГ | БТ | | Цахимаар зарласан тендер шалгаруулалтын хувь-100 | Цахимаар зарласан тендер шалгаруулалтын хувь-100 | | | 2022 онд аймгийн хэмжээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 18,603.26 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 79 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 18,018.19 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 75 бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахимаар зарласан тендерийн эзлэх хувь-100 хувь | 100 |
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | | **99.9** |
| **Уул уурхай, хүнд үйлдвэр** | | | | | | | | | | | | |
| **3.2. Ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрийг хөгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| 68. | 3.2.1. Хүнд | 1. Хүнд үйлдвэрийн | 2021- | Айма | УТХ | | Боловср | Үйлдвэрийн | | | Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, | 30 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрийн бүс байгуулж, боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | бүс байгуулж, боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 2024 | г, сумдын ЗДТГ | О, ХХО | | уулах үйлдвэрийн тоо-4 | бүсэд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг дуусгана.<br><br>Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо-1 | | | судалгааны ажил хийхээр аймгийн Засаг даргын 2021 оны А/07 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, 3 удаа хуралдан Чойр хотын тэг гортигийн хил заагийг тэлэх, хэсэгчилсэн болон дахин төлөвлөлт хийх байршлыг тодорхойлох, орон сууц, үйлчилгээний газруудын цаашдын төлөвлөлтийг тодорхойлох асуудлуудыг хэлэлцэн судалгааг гаргаад байна.<br>2022 онд ажлын хэсэг 2 удаа хуралдаж Сүмбэр сумын иргэдээс санал асуулга авсан. Шинээр байгуулагдах үйлдвэрийн санал ирээгүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын бэлтгэл ажил хангагдаж байна.<br>Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо-0 | |
| 69. | 3.2.2. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2. Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээг авна. | 2021-2024 | АЗДТГ, БОАЖГ | ХХО | - | Зохион байгуулсан арга хэмжээ – 3<br><br>Хуулийн хэрэгжилтийг хангуулна. | Хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээ авна. | | | Аймгийн хэмжээнд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа 2 компани байгаагаас ШОХК нь хууль, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Харин “Эйкүсора” ХХК-ийн үйл ажиллагааг хууль зөрчсөн үндэслэлээр түдгэлзүүлж, шүүхээр хянагдаж байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2 | 90 |
| 70. | | 3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллана. | 2021-2024 | АЗДТГ | БТ | | Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо-219-аас доошгүй | Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо-60-аас доошгүй | | | Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж, экспортод гаргаж байгаа 219 байгууллагатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн Засаг дарга, Сүмбэр сумын Засаг дарга, холбогдох нутгийн захиргааны байгууллагаас санаачлан аж ахуйн нэгжүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, үүрэг чиглэл өгч ажилласан.<br>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Гаалын хяналтын бүсэд ачилт, буулгалтын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн ачааны тонн тутмаас төлбөр авах журам, төлбөрийн хэмжээ батлах тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан 2022 онд 40.9 сая төгрөгийн төлбөр орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан байгууллагын тоо-219 | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 71. | 3.2.3. Хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, эрх ашгийг хамгаалан дэмжинэ. | 4. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 2021-2024 | АЗДТГ | Гадаадын зээл тусламж | 2,050.0 | Өвсний үндэс буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн их засварын ажил хийгдсэн | Өвсний үндэс буцалтгүй тусламжийн хөтөлбөрт хүргүүлэх төслийн тоо-2 | 1,100.0 | | Японы Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрт 6 төслийг хэрэгжүүлэхээр саналыг хүргүүлснээс анхан шатанд 1 төсөл дэмжигдсэн. /Халдвартын эмнэлгийн их засвар/<br>Мөн БНСУ-ын Эксим банкны хөрөнгө оруулалтаар “Дулааны цахилгаан станц”, Польш улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар “Цэвэрлэх байгууламж барих” төслийн гэрээ байгуулагдан, барилгын ажлуудыг эхлүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн төслийн тоо-2<br>Өвсний үндэс буцалтгүй тусламжийн хөтөлбөрөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн төслийн тоо-1 / эхлээгүй/ | 100 |
| 72. | | 5. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийхийг бодлогоор дэмжинэ. | 2021-2024 | АЗДТГ | ХХО | | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлын тоо 0 | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийхийг бодлогоор дэмжинэ. | | | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд “ОСО констракшн” ХХК, “Юникл тауэр” ХХК- тай тус тус гэрээ байгуулан 330 айлын орон сууц барих ажлыг эхлүүлсэн.<br>Аймгийн төвд авто үйлчилгээний төв байгуулах ажлыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд концессын зүйлийн жагсаалтад тусган батлуулсан. Мөн Авто тээврийн үндэсний төв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар уг төслийг хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна. Авто үйлчилгээний төв барих 2 га газрыг Сүмбэр сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан батлуулахаар саналыг хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төслийн тоо - 2<br>Концессын зүйлийн жагсаалтад тусган батлуулсан төслийн тоо - 1 | 90 |
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | **82.0** |
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр** | | | | | | | | | | | |
| **3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангах хувь хэмжээг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.** | | | | | | | | | | | |
| 73. | 3.3.1. Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний | 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, хүнсний гол түүхий эд, бүтээгдэхүүн мах, сүүний хангамжийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХХААГ | УТХО, ОНХС | | Саалинд хамруулсан хээлтэгч 76873 үйлдвэрлэсэн сүү 2633 тн | Саалинд хамруулсан хээлтэгч 3-5 хувиар нэмэгдсэн байна.<br><br>Аймгийн жишсэн | | | Аймгийн хэмжээнд нийт төллөвөл зохих 165206 хээлтэгчээс төллөсөн 155200, үүнээс төллөвөл зохих ингэний 62.5 хувь буюу 137, гүүний 75.9 хувь буюу 5331, үнээний 77.2 хувь буюу 4396, эм хонины 93.0 хувь буюу 84808, эм ямааны 99.0 хувь буюу 60528 төллөв. Төллөсөн нийт хээлтэгчийн 51 хувь буюу 79152 эх малыг саалинд хамруулж, 3064 тн сүү үйлдвэрлэснээс, саалинд хамрагдсан үнээ 3519, бэлтгэсэн сүү 1899 тн, саалинд хамрагдсан ямаа | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах хувь хэмжээг нэмэгдүүлэн, атрын IY аяны хэрэгжилтийг оновчтой зохион байгуулна. | | | | | | Хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн мах 2700 тн<br>Боловсруулсан мах 45 тн<br>Боловсруулсан сүү 40 тн<br>Гахай, тахианы мах 3 тн | дундаж хүн амын хэрэгцээний боловсруулсан махны хэмжээ 8 хувь, сүүний хангамж 5 хувь<br><br>Гахай, тахианы махны хэмжээ 1 хувиар өссөн байна. | | | 48422, бэлтгэсэн сүү 1162.1 тн байна.<br>2022 онд дотооддоо 2985 тн мах үйлдвэрлэснээс хүнсний дотоод зах зээлд 2205.4 тн мах, төвлөрсөн зах зээлд 115.0 тн, малчин өрх дотоод хэрэгцээндээ 664.6 тн махыг хэрэглэжээ.<br>2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд иргэдийн махны хэрэгцээнд мах бэлтгэн нийлүүлэгч 4 ААН-үүдтэй бодлогын гэрээ байгуулан өвөл, хаврын улиралд нийлүүлэх 100 тн мах нөөцлөн, түүний 30 хувийг орон нутагт нийлүүлэхээр хөргүүртэй агуулах бүхий ААН-үүдтэй хамтран ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын нөөцөөс 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд 20.0 тн махыг нөөцөлж, хавар үнийн тогтвортой байдлыг хангуулах зорилгоор хөнгөлөлттэй үнээр борлуулах 1 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулав.<br>Уламжлалт үйлдвэрлэлээр нийт 3064 тн сүү, боловсруулсан мах 51 тн, сүү 48 тн үйлдвэрлэсэн нь аймгийн нийт жишсэн дундаж хэрэгцээний махны 100 хувь, сүүний 86.4 хувь, боловсруулсан махны 6.2 хувь, сүүний 5.1 хувийг хангасан үзүүлэлттэй байна.<br>2022 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар аймгийн хэмжээнд гахайн өрхийн аж ахуй 22, аж ахуйн нэгж 1, нийт гахайн тоо 321, үүнээс үндсэн мэгж 97, шувууны өрхийн аж ахуй 9, нийт тахиа 130 Үүнээс өндөглөгч 71 байна. Үйлдвэрлэсэн өндөг 12.8 мян.ш, гахайн мах 5 тн байна.<br>2022 онд Сүмбэр суманд тахианы мах боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех ашиглалтад орж 0.4 тн махыг боловсруулан зах зээлд нийлүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Саалинд хамрагдсан хээлтэгч өмнөх оноос 39.0 мян.тол буюу 17 хувиар нэмэгдсэн<br>Өмнөх оноос аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээний боловсруулсан махны хэмжээ 6 тн-оор 13 хувь, шингэн сүүний хангамж 8 тн-оор нэмэгдэж, 20 хувиар тус тус өссөн.<br>Гахайн мах үйлдвэрлэл 2 тн-оор өсч буюу 60 хувь, тахианы махны хэмжээ 0.4 тн буюу 40 хувиар өссөн байна. | |
| 74. | | 2. Газар тариалангийн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, хүнсний гол нэрийн | 2021-2024 | ХХААГ | ОНХС | | Эргэлтийн талбайн хэмжээ-79 га, | Эргэлтийн талбайн хэмжээ-78 га,<br><br>Талбайн | | | 2022 онд шинээр газар тариалан эрхлэгч 17-оор нэмэгдэж, эргэлтийн талбай 94 га-д хүрсэн.<br>Хөнгөлөлттэй нөхцөлөөр 11 төрлийн хүнсний ногооны үрийг давхардсан тоогоор 78 иргэн, аж ахуй нэгжид, “Эрүүл хүнс, эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 3 тн төмсний, 200 кг төл сонгины үр, 1000 ш өргөст | 85.9 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтээгдэхүүн төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлнэ. | | | | | Талбайн ашиглалтын хувь-80.7<br><br>Усралтын системийн ашиглалтын хувь 66,<br><br>Төмс, хүнсний ногооны хангамжийн хувь-27.2,<br><br>Зоорь, агуулахаас нийлүүлэх төмс, хүнсний ногоо- 75 тн | ашиглалтын хувь-50,<br><br>Услалтын системийн ашиглалтын хувь-60,<br><br>Төмс, хүнсний ногооны хангамжийн хувь-23,<br><br>Зоорь, агуулахаас нийлүүлэх төмс, хүнсний ногоо-55 тн | | | хэмх, улаан лоолийн үрсэлгээг 45 иргэн, аж ахуй нэгжид тус тус олгож, 21 га талбайд төмс, 31.2 га талбай хүнсний ногоог тариалж, талбайн ашиглалтыг 93.0 хувьд хүрсэн.<br>Шивээгийн булгийн услалтын системд 6 иргэн, ААН 6.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалан, 55.2 тн ургац авсан ба услалтын системийн ашиглалт 86.6 хувь байв.<br>Аймгийн хэмжээнд 177 тн төмс, 247.6 тн хүнсний ногоо, нийт 424.6 тн ургац хураан авсан. Үүнийг аймгийн жишсэн дундаж хэрэгцээгээр тооцоход төмсний 24.5 хувь, хүнсний ногооны 24 хувийг хангасан үзүүлэлттэй байна<br>Сүмбэр, Шивээговь сумын 2 ААН, 1 иргэн нийт 35 тн төмс, хүнсний ногоог зооринд хадгалсан байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эргэлтийн талбай /га/-94<br>Талбайн ашиглалт /хувь/-93<br>Услалтын системийн ашиглалт /%/-86.6<br>Төмс, хүнсний ногооны хангамж /%/-24.2<br>Зоорь агуулахад хадгалсан төмс, хүнсний ногоо /тн/-35 | |
| 75. | | 3. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг дэмжиж, дотоод үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХХААГ, СЗДТГ | АОНХС | 25.0 | Хүлэмжийн тоо-5<br><br>Талбайн хэмжээ-640м2-аар нэмэгдсэн. | Шинээр бий болох өвлийн хүлэмжийн тоо - 1, талбай 36 м.кв Улирлын хүлэмжийн тоо, талбайг өмнөх онтой харьцуулахад 15 хувиар нэмэгдүүлнэ | 15.0 | | ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгтэйгээр “Чойрын гурван богд” хоршоо 300 м.кв талбай бүхий өвлийн хүлэмжийг барьж ашиглалтад оруулсан.<br>Аймгийн 2022 оны ОНХС-ийн 112.4 сая төгрөгийн хөрөнгөөр 37 хүлэмжийг авч, төсөл сонгон шалгаруулалтад хүнсний ногоо, мод үржүүлгийн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид олгосон. Үүний үр дүнд хамгаалагдсан хөрсний тариалалтын талбайг 2504 мкв-аар нэмэгдэж, 6904 мкв болж, хүлэмжээс 85.6 тн хүнсний ногоо хураан авч, 181700 тарьц, суулгац бэлтгэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр бий болсон өвлийн хүлэмжийн тоо-1, талбайн хэмжээ 300 мкв<br>Шинээр бий болсон улирлын хүлэмжийн тоо-37 / өмнөх онтой харьцуулахад 86.4 хувиар нэмэгдсэн.<br>Талбайн хэмжээ өмнөх оноос 2504 мкв-аар буюу 74.4 | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хувиар нэмэгдсэн. | |
| 76. | | 4. Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, механикжуулалтын түвшинг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХХААГ | ХХО | 95.0 | Төмс үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг 71.4 хувь, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг 75 хувьд хүргэсэн. | Төмс үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг 50 хувь, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг 38 хувьд хүргэнэ. | 20.0 | | Шинэ хөдөө төслийн хүрээнд хүнсний ногооны 10 мөртэй үрлэгч 1 ш, 1 мөртэй үрлэгч 10 ш нийлүүлэгдэн хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг нэмэгдүүлсэн.<br>Мөн ХААДС-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1 иргэн, 1 хоршоог техник, тоног төхөөрөмжөөр хангасан. 2022 онд Шивээгийн булгийн техник үйлчилгээний цэгээс 15 га талбайд техникийн үйлчилгээ үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төмсний механикжуулалтын түвшин 71.4 хувь, хүнсний ногооны механикжуулалтын түвшин 75.3 хувьд хүрсэн. | 100 |
| 77. | | 5. Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр, төрөл, хэмжээг нэмэгдүүлэн, хангалтыг сайжруулна. | 2021-2024 | ХХААГ | АОНХС | - | Аймгийн хүн амын гол 9 төрлийн хүнсний хэрэгцээний хангалтын дундаж -38.2 хувь, зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо-2 | Аймгийн хүн амын гол 9 төрлийн хүнсний хэрэгцээний хангалтын дундаж -35 хувь<br><br>Зохион байгуулах нөлөөллийн арга хэмжээний тоо-3 | | | Мал аж ахуйн үйлдвэрлэлээс түүхий сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн 2 удаагийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан, 407 малчин өрхийг хамруулж, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд хөнгөлөлттэй болон үнэгүй үр, үрслэг олгох, хүнсний ногооны урамшууллыг олгох ажлыг зохион байгуулан, үйлдвэрлэгчдийг цахим бүртгэлд бүрэн хамруулах сургалт, мэдээлэл өгөх арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 93 иргэн, 9 аж ахуйн нэгжийг хамруулж, малчид болон үйлдвэрлэл эрхлэгчдийг арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.<br>Үүний үр дүнд аймгийн хүн амыг гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлээс хангасан хүнсний хангамж 36 хувь, 9 төрлийн хүнсний бүтээгдэхүүний хангалт дунджаар 38.2 хувьд хүрсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>9 төрлийн хүнсний хэрэгцээний хангалт-38.2 хувь<br>Дотоод үйлдвэрлэлээс хангасан хувь-36.0<br>Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ-5 | 100 |
| 78. | | 6. Төрөөс баримтлах бодлого, атрын IY аяны хэрэгжилтийг орон нутгийн онцлогт тохируулан оновчтой хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХХААГ | АОНХС | - | Атрын IY аяны төлөвлөгөөг гарган батлуулсан, | Төлөвлөгөөний хэрэгжилт-90 хувь | | | Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 0425 дугаар нээлттэй хорих ангийг түшиглэн хүлэмжийн цогцолбор байгуулж байна. Тус төслийн хүрээнд цогцолборыг 10 хүлэмжээр хангаж, модны 36000 тарьц, суулгацыг үржүүлж, 1200 м.кв талбайд нарийн ногоо тариалж, тарьц, суулгацын ургалт 82 хувьтай | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 79. | | | | | | | төлөвлөгөөний хэрэгжилт-80 хувь | | | | ургаж, 1 тн нарийн ногоо хураан авсан байна.<br>Мөн Хүнсний хясаа мөөгийг хөрсгүй орчинд тариалах аргыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлж, борлуулалтын каластерийг хөгжүүлж байна. /Чойрын гурван богд хоршоо/<br>Газар тариаланд төмс, хүнсний ногоог хөрсний гадаргууд сүрлэн хучилттай тариалалт хийх технологийг нутагшуулах туршилт хийж, ургацын хэмжээг 3 дахин нэмэгдүүлэх боломжтой болохыг тогтоосон. /Оорцог элгэн хоршоо/<br>Газар тариаланд 4 шинэ сортыг /төмрийн агууламжтай помидор, уутат помирдор, хар манжин, төмсний Солист сортын элит үр / туршиж, нутагшуулсан. /Газар тариалан эрхлэгчид – Уртнасан, Нүүрхүү, Ганбаатар/<br>Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор хүлэмж, дуслын системийг өмнөх оны мөн үеэс 37 тоогоор буюу 2504 мкв талбайгаар нэмэгдүүлж, мөн хэмжээний талбайн усжуулалтыг шийдвэрлэсэн.<br>“Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд ХХААХҮЯ-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож буй 11 төрлийн үрийг давхардсан тоогоор 78 иргэн, аж ахуй нэгжид, “Эрүүл хүнс, эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 3 тн төмсний, 200 кг төл сонгины үр, 1000 ш өргөст хэмх, улаан лоолийн үрсэлгээг 45 иргэн, аж ахуй нэгжид тус тус олгосон нь эргэлтийн талбайг 94 га-д хүргэж, нийт 177 тн төмс, 247.6 тн хүнсний ногоо хураан авсан бөгөөд төмсний тариалалтад шинээр Солист сортын элит үрийг ашигласан. Тариалалтад ашигласан нийт үрийн 85 хувийг хяналт, баталгаажуулалтад хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нэмэгдсэн шинэ сорт-4<br>Усжуулагдсан, хамгаалагдсан хөрсний тариалсан талбай 2504 мкв<br>Тухайн жилийн төлөвлөсөн арга хэмжээний биелэлт 95 хувь | |
| 79. | 3.3.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах, бэлчээрийн менежментийг сайжруулан, тогтвортой байдлыг | 7. Бүс нутагт тохирсон мал аж ахуйг үржүүлж, хөгжүүлнэ. | 2021-2024 | ХХААГ | АОНХС | | Мэргэжлийн байгууллагын хяналтад авсан богийн хээлтүүлэгч ийн-63.5 | Бог хээлтүүлэгчийг-100 хувь, бодын хээлтүүлэгчийг-65 хувиас доошгүй мэргэжлийн байгууллагы | | | Аймгийн дүнгээр ялгавал зохих богийн хээлтүүлэгч 2554, ялгасан 1360 буюу 53.3 хувийг 8 суурьт ялган төвлөрүүлж, ялгасан нийт хээлтүүлэгчийн 98.8 хувийг мэргэжлийн үйлчилгээний нэгжийн хяналтад авсан.<br>Нийт 12208 толгой бог малыг үзлэг ангилалтад хамруулснаас 1828 буюу 15 хувь нь цөм сүрэгт, 7489 буюу 61.3 хувь нь үржлийн сүрэгт, 2881 буюу 23.6 хувь нь хэрэгцээний сүрэгт ангилагдсан байна.<br>Нутгийн монгол 150 үхрийг ангилалтад хамруулж, 96 буюу 64 хувийг цөм сүрэгт, 27 буюу 18 хувийг үржлийн | 72.8 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж, “Монгол мал II” арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулна. | | | | | | хувь, бодын /бухны/7.4 хувийг хувийг.<br><br>Үржлийн болон цөм сүрэгт ангилагдсан мал сүргийг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлын гүйцэтгэл-100% | н хяналтад авна.<br><br>Үржлийн болон цөм сүрэгт ангилагдсан мал сүргийг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлын гүйцэтгэл-70 хувиас доошгүй | | | сүрэгт, 27 буюу 18 хувийг хэрэгцээний сүрэгт ангилсан байна. Шинээр ээмэглэсэн 1828 бог, 150 үхэр байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Мэргэжлийн байгууллагын хяналтад авсан бог хээлтүүлэгч 1360 буюу 53.25 хувь<br>Бодын хээлтүүлэгч байхгүй байна.<br>Цөм сүрэгт ангилагдсан мал сүргийг 100 хувь, үрлийн сүрэгт ангилагдсан мал сүргийг 64.6 хувь ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн. | |
| 80. | | 8. Монгол мал II хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийг оновчтой зохион байгуулна. | 2021-2024 | ХХААГ | АОНХС | 11.5 | Монгол мал II үндэсний хөтөлбөр батлагдаагүй. | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт-100 хувь | 2.0 | | Монгол мал үндэсний хөтөлбөр 5 зорилтын хүрээнд 2021 оны жилийн эцэс хүртэл хэрэгжиж дууссан. Уг үндэсний хөтөлбөрийн хүрээнд малын үржил, селекцийн арга хэмжээнд аймгийн ОНХС-аас 3.5-8.0 сая төгрөгийн санхүүжилтээр сүүлийн 3 жилд богийн зохиомол хээлтүүлэг хийх ажлыг 8 хувиас дээш, зохиомол хээлтүүлгийн зөөврийн пункет ашиглалтад оруулах, бэлчээрийн хөнөөлт мэрэгчтэй тэмцэх арга хэмжээг 2018-2020 онд 20.0-30.0 мян.га бэлчээрт 85 хувиас дээш, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг чанарын 85 хувиас дээш үр дүнтэй хэрэгжүүлэн ажилласан гэж хөндлөнгийн үнэлгээгээр дүгнэсэн байна.<br>Хөтөлбөр дууссан ч 2022 онд малын тооноос чанарт илүү анхаарч, хонь, үхрийг махны чиглэлээр сайжруулах, махны чиглэлийн Беричон душер хонийг цэврээр үржүүлэх санаачилгыг дэмжин ажиллаж байна. Мөн бэлчээрийн тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор малчдын бүлгээр тэжээлийн таримал тариалах ажлыг үнэгүй үр олгож, тарих технологийг зааж өгснөөр нийт 12 бүлэг 1.2 га бэлчээрт тэжээлийн ургамал тариалан 1.1 тн тэжээл хураан авсан байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Монгол мал-II үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд 100 хувь зохион байгуулан | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ажилласан.<br>Тус үндэсний хөтөлбөрийн хугацаа дууссан бөгөөд шинэ хөтөлбөр батлагдаагүй байна.<br>Хөтөлбөр хэрэгжиж дууссан ч тухайн хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх, бодлогын залгамж чанарыг хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж байна.<br>Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувь. | |
| 81. | | 9. Байгалийн хадлан бэлтгэж, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тэжээлийн нөөц бүрдүүлнэ. | 2021-2024 | ХХААГ | ХХО | 240.0 | Хадлан бэлтгэсэн салааны тоо-6, иргэний тоо-2<br>Тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээ-12.9 га, хураасан тэжээл-40 тн | Хадлан бэлтгэсэн салааны тоо-6, иргэний тоо-3<br><br>Тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээ-53 га, хураасан тэжээл-100 тн | 60.0 | | Аймгийн хэмжээнд хадлангийн 6 салаа, 4 иргэн Хэнтий аймгийн Дархан сум, Дорнод аймаг болон орон нутагтаа хадланд гарч, 113 тн байгалийн хадлан бэлтгэж, 22 тн өвсийг орон нутгийн малчин өрхүүдэд борлуулж, 91 тн өвс нөөцөлсөн.<br>Өвөлжилтийн бэлт хангах ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 152 тн өвс, 58 тн тэжээл бэлтгэн ЗГ-ын 2022 оны 277 дугаар тогтоолоор үүрэг болгосон квотыг 100 хувь хангасан. Сумдын аюулгүйн нөөцөд бэлтгэвэл зохих 150 тн өвс, 75 тн тэжээлийн 77.4 хувийг буюу Сүмбэр сум 50 тн өвс, 20 тн тэжээл бэлтгэж, биелэлт 90 хувь, Баянтал сум 35 тн өвс, 18.1 тн тэжээл бэлтгэж, биелэлт 71.2 хувь, Шивээговь 35 тн өвс, 18 тн тэжээл бэлтгэж, биелэлт 71 хувь, сумдын нийт дүнгээр тогтоолын биелэлт 77.4 хувь байна.<br>33 иргэн 42 га талбайд тэжээлийн олон наст 3 төрлийн таримал тариалж, 115 тн тэжээл хураан авсан. Малчин өрхийн түвшинд нийтдээ 4463 тн өвс, 236 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэж, хашаа хороо, уст цэгийн бэлэн байдлыг 96.3-100 хувь хангаж, малчин өрхийн өвлийн бэлтгэл 88.7 хувь байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хадлан бэлтгэсэн салаан тоо-6, иргэний тоо-4<br>Тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээ 42 г,<br>Хураасан тэжээл 115 тн | 93.1 |
| 82. | | 10. Бэлчээрийг зохистой ашиглах менежментийг сайжруулан, бэлчээрийн усан хангамжийг | 2021-2024 | ХХААГ | ХХО<br>СО | 90.0<br>25.0 | Малчдын албан бус бүлэг-12<br><br>Хөнөөлт | Малчдын албан бус бүлэг-12<br><br>Хөнөөлт мэрэгчдийн | 30.0 | | Аймгийн хэмжээнд 2022 онд бэлчээр ашиглалтын хэлбэрээр зохион байгуулагдсан малчдын албан бус 36 бүлэг байна. Үүнээс: Баянтал суманд 6, Сүмбэр суманд 28, Шивээговь суманд 2.<br>Малчдын бүлгүүдэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажлыг 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор | 91.3 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оновчтой төлөвлөж, зохистой ашиглана. | | | НХС | | мэргэдийн тархалтын судалгаа хийсэн талбайн хэмжээ-70.0 мян.га<br><br>Тэмцсэн талбай байхгүй. Зохион байгуулсан сургалтын тоо-2<br><br>Бэлчээр ашиглалтыг сайжруулахад оролцсон малчдын оролцоо-17.2 хувь | тархалтын судалгаа хийх талбайн хэмжээ-30.0 мян.га<br><br>Судалгаанд үндэслэн бэлчээр сайжруулах арга хэмжээ зохион байгуулна<br><br>Бэлчээрийн менежментийг сайжруулах сургалтын тоо-2<br><br>Бэлчээр ашиглалтыг сайжруулахад малчдын оролцоо-20 хувь | 10.0 | | 1407 малчинг хамруулсан.<br>Малын тоо толгойн татварын орлого, МАА-н үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт бэлчээр ашиглалт сэдвээр сургалт зохион байгуулж, сумдын хүнс, хөдөө аж ахуйн тасгийн 20 албан хаагч, Сүмбэр сумын 65, Баянтал сумын 74 малчныг хамруулсан.<br>Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготны тандалт судалгааг Баянтал суманд 12000 га талбайд хийж, 5000 га талбайд биологийн аргаар тэмцэх ажлыг малчдын бүлэгтэй хамтран зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Малчдын албан бус бүлгийн тоо-36<br>Хөнөөлт мэрэгчдийн тархалтын судалгаа хийсэн талбайн хэмжээ 17.0 га<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо-1<br>Бэлчээрийн менежментийг сайжруулах сургалтын тоо-3<br>Бэлчээр ашиглалтыг сайжруулахад малчдын оролцоо 58.6 хувь | |
| 83. | 3.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ. | 11. Уламжлалт мал аж ахуйд биотехнологийн ололтыг нэвтрүүлж, нэг малаас авах ашиг шимийн гарцыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХХААГ | АОНХС<br><br>ХХО | <br><br>80.0 | Ноолуурын микроны шинжилгээ хийгдээгүй.<br><br>Ноолуурын дундаж гарц 0.460 кг<br><br>Ноосны дундаж гарц | Ноолуурын микроныг 1.0 хувиар багасгана.<br><br>Ноосны дундаж гарцыг 1.0 хувиар нэмэгдүүлнэ.<br><br>Хонины махны дундаж гарцыг 1.8 хувиар | <br><br>20.0 | | Мал аж ахуйг тооноос чанарт шилжүүлэх, ашиг шимийг сайжруулах зорилтын хүрээнд МААЭШХ, мэргэжлийн “Зоо донитор” нэгжтэй хамтран технологит ажлыг зохион байгуулж байна.<br>125 малчин өрхийн 35620 толгой ямаанд ноолуурын хяналтын хэмжилт хийхэд ноолуурын дундаж гарц Баянтал суманд 0.429 кг, Сүмбэр суманд 0.495 кг, Шивээговь суманд 0.497 кг, аймгийн хэмжээнд дундаж гарц 0.473 кг байгааг өмнөх онтой харьцуулахад ноолуурын гарц 0.13 кг-аар нэмэгдсэн байна.<br>Ноолуурын микроныг тогтоох ажилд 100 ямаанаас дээж аач МААЭШХүрээлэнд тодорхойлуулсан ба дунджаар 16.6 микрон байгаа нь микроны хэмжээ 0.9 хувиар буурсан байна.<br>84 өрхийн 30912 хонинд ноосны дундаж гарц тогтоох хэмжилт хийхэд дундаж гарц 1.5 кг буюу норматив хэмжээнд байна. | 96.6 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 25 хувиар нэмэгдсэн.<br><br>Хонины махны дундаж гарц өмнөх оноос 4.9 кг буюу 20.8 хувиар нэмэгдсэн | нэмэгдүүлнэ. | | | Хонийг 10-11 сартай хурга, төлгөнд, ухрийг бяруу, шүдлэн насанд нь эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг сүүлийн 3 жилд үе шаттай хэрэгжүүлж байна. Хурганы гулуузны дундаж гарц 16 кг, төлөгний гулуузны дундаж гарц 22 кг байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 10-15 хувиар нэмэгдсэн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ноолуурын микроныг 0.9 хувиар багасгана.<br>Ноосны дундаж гарцыг 1.0 хувиар нэмэгдсэн<br>Хонины махны дундаж гарцыг 10 хувиар нэмэгдсэн. | |
| 84. | | 12. Хүнсний үйлдвэрлэлд гахай, тахианы мах, өндөг нийлүүлэх аж ахуйн хөгжлийг дэмжинэ. | 2021-2024 | ХХААГ | АОНХС<br><br>ХХО | <br><br>20.0 | Эрчимжсэн мал аж ахуйн бүсэд гахайн аж ахуйн 40 хувь үйл ажиллагаа явуулж байна.<br><br>Дэмжлэг авсан гахай, тахиан аж ахуй байхгүй Үйлдвэрлэсэн өндөгний тоо 7.8 мянга, Гахайн махны хэмжээ 3 тн, Тахианы | Дэмжлэг авсан гахайн өрхийн аж ахуйн тоо-1,<br><br>шувууны өрхийн аж ахуйн тоо-1<br><br>Үйлдвэрлэсэн өндөгний тоо- 15000-аас багагүй, гахайн махны хэмжээ 1.5 тн-оос багагүй, тахианы махны хэмжээ 0.1 тн-оос багагүй байна. | <br><br>5.0 | | 2022 онд аймгийн хэмжээнд гахайн өрхийн аж ахуй эрхлэгч 22, аж ахуйн нэгж 1, нийт гахайн тоо 321, үүнээс үндсэн нэгж 97, шувууны өрхийн аж ахуй 9, нийт тахиа 130, үүнээс өндөглөгч 70 байна.<br>Үйлдвэрлэсэн гахайн мах 5 тн, эцсийн боловсруулалт хийсэн тахианы мах 0.4 тн, үйлдвэрлэсэн өндөг 12 мян.ш.<br>Эрчимжсэн мал аж ахуйн бүсэд 4 өрхөд газар олгон гахайн аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд 66 гахай үржүүлж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дэмжлэг авсан гахайн өрхийн аж ахуйн тоо-4<br>Дэмжлэг авсан шувууны өрхийн аж ахуйн тоо-0<br>Гахайн өрхийн аж ахуйн тоо -22<br>Шувууны өрхийн аж ахуйн тоо -9<br>Үйлдвэрлэсэн өндөгний тоо- 12000<br>Гахайн махны хэмжээ 5 тн<br>Тахианы махны хэмжээ 0.4 тн | 70.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | махны хэмжээ 0 тн | | | | | |
| 85. | | 13. Мал аж ахуйн гаралтай экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХХААГ | УТХО<br>АОНХС<br>ХХО | <br><br>35.0 | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ Хамрагдсан үйлдвэрлэгч 100 Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо 48527 ширхэг Угаасан ноосны хэмжээ-800 тн<br><br>Ангилсан махны хэмжээ-40тн<br><br>Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 11.7 хувиар буурсан байна. | Нөлөөллийн арга хэмжээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн 60-аас доошгүй хувийг хамруулна.<br><br>Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо 58963 ширхэг<br><br>Угаасан ноосны хэмжээ-250 тн -оос багагүй<br><br>Экспортолсон ноосны хэмжээ- 75 тн-оос багагүй<br><br>Ангилсан махны хэмжээ-2.3 тн-оос багагүй<br><br>Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 1.5 хувиар өссөн байна. | <br><br>15.0 | | Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх биржээр түүхий эдээ арилжаалах, анхан шатны боловсруулалт хийх технологийн мэдлэг олгох чиглэлээр 4 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 63 үйлдвэрлэл эрхлэгч буюу нийт үйлдвэрлэл эрхлэгчийн 80 хувийг хамруулсан байна.<br>2022 онд арьс, нэхий боловсруулах цех ашиглалтад орж, 3200 ш нэхийг боловсруулан зах зээлд нийлүүлсэн.<br>2022 онд 5 цэгээс 80.2 тн ноолуур, 2.5 тн дэл сүүл, 70 мян ширхэг түүхий бэлтгэн, анхан шатны тордолт хийж, үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлсэн байна.<br>Чойрхайрхан ХХК 300 тн ноос угааж, 45 тн ноос самнаж, 30.0 мян.метр эсгий үйлдвэрлэсэн.<br>Аймгийн төвийн хүн амын хэрэгцээнд ангилан бэлтгэсэн 4.2 мах, махан бүтээгдэхүүнийг нийлүүлээд байна.<br>Сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол түүхий эд болох ээрмэл утасны нийлүүлэлт багасаж, үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Үйлдвэрлэсэн арьс ширний тоо-3200 ширхэг<br>Угаасан ноосны хэмжээ - 300 тн<br>Экспортолсон ноосны хэмжээ - 82.7 тн<br>Ангилсан махны хэмжээ - 4.2 тн<br>Сүлжмэл бүтээгдэхүүний хэмжээ - 0 | 66.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 86. | 3.3.4. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалан, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэн, малчдыг өвс, тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно. | 14. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, ган, зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэй, үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ, ХХААГ | АОНХС | 320.0 | Зудын эрсдэлийн үнэлгээ хийгдсэн.<br><br>Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилт-85.4 хувь | Эрсдэлийн үнэлгээ хийнэ.<br><br>Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилт-90 хувь | 80.0 | | Эрсдэлийн үнэлгээг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулж байгуулсан.<br>Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 13 арга хэмжээтэйгээр 2022 оны 08 дугаар сарын 16–ны өдрийн 01 дүгээр албан даалгавраар батлагдаж, төлөвлөгөөний 85.7 хувийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Үүнд:<br>**Өвс, тэжээлийн нөөц**: Аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 152 тн өвс, 58 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэсэн.<br>**Сумдын аюулгүйн нөөц бүрдүүлэлт**: Сүмбэр 50 тн өвс, 20 тн тэжээл бэлтгэсэн, Баянтал 35 тн өвс, 18,1 тн тэжээл, Шивээговь сум аюулгүйн нөөцдөө 35 тн өвс, 18 тн тэжээл нөөцөлсөн.<br>Аймгийн хэмжээнд хадлангийн 6 салаа, 4 иргэн Хэнтий аймгийн Дархан сум, Дорнод аймаг болон орон нутагт хадланд гарч 113 тн өвс бэлтгэж, 22 тн өвсийг орон нутгийн малчин өрхүүдэд борлуулсан. 91 тн өвс нөөцөлсөн байна.<br>Аймгийн дүнгээр 33 иргэн 42 га.талбайд тэжээлийн ургамал тариалж, 115 тн тэжээл хурааж авсан. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил малчин өрхийн түвшинд 88.7, аймгийн нэгдсэн дүнгээр 87.5 хувьтай хангагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн.<br>Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-85.7 | 92.9 |
| 87. | | 15. Байгаль цаг уурын эрсдэлийг бууруулах, чадавхаа дээшлүүлэх чиглэлээр малчдад нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулна. | 2021-2024 | ХХААГ, СЗДТГ | АОНХС | | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо-8<br><br>Хамрагдсан малчин өрхийн тоо-812 | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо 7-оос доошгүй /сургалт 2, аян 2, хэлэлцүүлэг 1, бүлгийн сургалт, мэдээлэл 2/ | | | Малчдыг аж ахуйгаа эдийн засгийн хувьд ашигтай, байгаль цаг уурын эрсдэлийг бууруулах, чадавхаа сайжруулахад нөлөөлөх зорилгоор Бэлчээр хамгаалах, ашиглалтыг сайжруулах чиглэлээр 3 төрлийн 5 арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>Малын гоц халдварт өвчин, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар 2 удаа, малын чанарыг сайжруулах чиглэлээр 2 төрлийн 4 арга хэмжээ, аж ахуйгаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр 2 төрлийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэн, малчдын 36 албан бус бүлэг, давхардсан тоогоор 768 малчид, сумдын Засаг дарга болон Засаг даргын Тамын газрын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан. | 96.9 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХХО | 168.0 | Чадавхаа сайжруулсан малчин өрхийн тоо-131 /Баянтал сумын малчны 3-н бүлэг-89 малчин өрх, Сүмбэр сумын 42 өрх/ | Хамрагдсан малчин өрхийн тоо-500-аас доошгүй<br><br>Чадавхаа сайжруулсан малчин өрхийн тоо 300-аас доошгүй | <br>30.0 | | **Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ 16; үүнээс аян 2, хэлэлцүүлэг 2, бүлгийн сургалт 9, сургалт мэдээлэл 3 зохион байгуулж, нийт 768 малчин өрхийг хамруулав. | |
| 88. | 3.3.5. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авч, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж, нийтийн эрүүл мэндийг хамгаална. | 16. Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг зохион байгуулна. | 2021-2024 | МЭГ | УТХО, ОНТ | - | Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо-106.6<br><br>Гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо-540.6 мян.тол<br><br>Зооноз | Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-106.2 мян.тол<br><br>Гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-1.050 мян.тол<br><br>Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-95 мян.тол | | | Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх 8 төрлийн дархлаажуулалтад 89.5 мян.тол мал хамруулахаас 88.9 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 99 хувь. Ужиг халдварт өвчнөөр тайван статусыг хангасан. Сохор догол өвчнөөс сэргийлэх вакцин технологит хугацаанд нийлүүлэгдээгүй тул ажил бүрэн дуусаагүй байна.<br>Гоц халдварт шүлхийн эсрэг хаврын дархлаажуулалтад 16.1 мян.тол үхэр ба гахай хамруулж, гүйцэтгэл 89 хувь, намрын дархлаажуулалтад 21.2 мян.тол үхэр ба гахай хамруулж, гүйцэтгэл 97 хувьтай дуусах шатанд шилжээд байна. Тус дархлаажуулалтыг хугацаанд нь чанартай зохион байгуулсны үр дүнд аймгийн мэдрэмтгий мал сүрэгт шүлхий тохиолдоогүй, тайван статустай байна.<br>Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 93.4 мян.тол мал хамруулахаас 89.0 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 95 хувь. Зоонозын халдварт бруцеллёзын эсрэг дархлаажуулалтыг жил бүр технологит хугацаанд зохион байгуулсан ба 3049 дээжинд илрүүлэх шинжилгээ хийхэд бүгд сөрөг дүн үзүүлж, өвчлөлийн хувь хэмжээг 2019 онтой харьцуулахад 2 хувиар буурч 0 хувьд хүрсэн үр дүн үзүүлсэн.<br>Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 639.3 мян.тол мал хамруулахаас 511.0 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 80 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-88.9 мян.тол | 79.4 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо-92.8 мян.тол<br><br>Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулсан малын тоо-411.5 мян.тол | Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-579.1 мян.тол | | | Гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-21.2 мян.тол<br>Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-89 мян.тол<br>Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-511.0 мян.тол | |
| | гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавхыг дээшлүүлнэ. | кибер халдлагатай тэмцэх хяналтыг хэрэгжүүлж, албан хаагчдыг чадавхжуулна. | 2024 | аагийн хэлтэс | | | сэн гэмт хэргийн тоо-0<br><br>Хамрагдсан алба хаагчдын тоо-1 | гэмт хэргийн тоо-0<br><br>Хамрагдсан алба хаагчдын тоо-6 | | | байдлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй, цахим орчинд залилах гэмт хэрэг 26, цахимаар мөрийтэй тоглоом зохион байгуулсан 6, заналхийлэх 21 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн.<br>Кибер аюулгүй байдлын эсрэг хэргийг илрүүлэх, цахим мэдээлэлд үзлэг хийх, цахим нотлох баримтыг бэхжүүлэх, тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаанд алба хаагчдыг мэргэшүүлж, 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 24 алба хаагчийг хамруулсан.<br>Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох “PC бүртгэл” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, шаардлагатай газруудын IP хаяг, төхөөрөмжийн мэдээллийг бүртгэлжүүлсэн.<br>Урьдчилан сэргийлэх зорилгоор 4 контент, 10 постер, 8 зурагт хуудас, 6 урьдчилан сэргийлэх санамжийг гарган, цахимаар 4309 иргэнд хүргэсэн.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Бүртгэгдсэн кибер гэмт хэргийн тоо-0<br>Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо-24 | |
| 160. | 4.3.7. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана. | 8. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | ОНТ | | Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь | Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь | | | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2022 оны төлөвлөгөөний хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөн 100 хувийн хэрэгжилттэй хэрэгжүүлсэн.<br>Төлөвлөгөөний дагуу аймгийн нутгаар дамжин өнгөрдөг босоо тэнхлэгийн нийт 110 километр үргэлжлэх А0101 А0102 дугаартай авто замд замын арчлалт хариуцсан “Саруул харгуй” ХХК-ны ажилчид зам тээврийн хэрэг, осол ихээр гардаг Баянтал сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Оорцог энгэр зөрлөгийн эвдрэл ихтэй 3 км үргэлжлэх замыг бүрэн хучиж, замын зорчих хэсгийн эвдрэл бүхий хэсгийг хэсэгчлэн засварлаж аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байна. Явган зорчигчийн аюулгүй байдал сургууль орчмын бүс хүүхэд нөлөөллийн арга хэмжээний хүрээнд ЗБИБ ХХК-ны ажилчид аймгийн төвийн явган зорчигч нарт зориулсан гарцын тэмдэглэл болон бусад тэмдэг тэмдэглэгээг тодруулж, 5.33а, 5.33б, 5.34а, 5.34б тэмдэг 8 ширхгийг байрлуулсан.<br>Удирдлагын жолоо ТББ нь хүүхдийг зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор олон автозам хөндлөн гарч гэр сургууль гэр гэсэн маршрутаар явдаг 1, 2-р сургуулийн 200 хүүхдэд гэрэл ойлгогчтой ханцуйвч, цүнхний уут зэргийг хүлээлгэн өгч зам хөндлөн гарахдаа хэрхэн зөв аюулгүй гарч хэвших талаар модуль сургалт зохион байгуулан ажилласан.<br>Коронавируст ковид-19 цар тахлын үед алба хаагчдын | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | болон иргэд жолооч нарын аюулгүй байдлыг хангах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор ALKO TEST 5000 шинэ төрлийн согтуурал тандагч багажийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн зардлаар 3 ширхгийг шийдвэрлүүлж Цагдаагийн хэлтсийн албан хэрэгцээнд ашиглаж байна. Замын цагдаагийн хяналтын постод 57.0 сая төгрөгийн өртөг бүхий дундаж хурдны камерт илэрсэн зөрчлийг, зөрчил гаргагчийн гар утасны дугаарт мессеж хэлбэрээр илгээх төхөөрөмжийн байршуулсан. Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн зардлаас зөрчил шалгах төхөөрөмжийн сунгалтад 1.070.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн.<br>2022 онд ЕБС, СӨБ сурагч, эцэг эх, асран хамгаалагчдад сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж 617 хүнийг хамруулсан байна.<br>ЕБС, СӨБ ойролцоох авто замын тэмдэг, тэмдэглэгээг стандартад нийцэж байгаа эсэхэд үзлэг, шалгалт хийж шинээр ашиглалтад орсон 2-р сургуулийн замын зорчих хэсэгт стандартын дагуу хурд сааруулагч шинээр хийлгэж, сургууль орчмын бүс тэмдэг, сургуулийн орчимд байх авто замын гарцыг хаалгуулахаар хариуцсан байгууллагад мэдэгдэл хүргүүлж ажилласан. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБ-ын 5-р сургуулийн гадна авто зогсоолд хашлага байрлуулж явган зорчигч нарт зориулсан гарцын тэмдэглэлийг шинээр хийж 5.19б тэмдэг байрлуулж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Ахлах дунд ангийн сурагчдад “Хүүхдийн эрх, хамгаалал, гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголт, урьдчилан сэргийлэх тухай” сэдвээр төв байгууллагаас ирүүлсэн мэдээллийг хүүхдийн анхаарал татахуйц байдлаар 15 минутын слайд бэлтгэн сургалт зохион байгуулах алба хаагчдад хүргүүлж, Сүмбэр сумын 1,2,5, Шивээговь сумын 3, Баянтал сумын 4-р сургуулийн дунд, ахлах ангийн 240 сурагчдад сургалт зохион байгуулж, бага ангийн сурагчдад Хүүхдийн аюулгүй байдлыг хангах сэдвээр Сэргийлэгч хүү, Зөвлөгч охины видео бичлэгийг 60 сурагчдад хүргэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 хувь.<br>Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3 үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үетэй адил хэмжээтэй байна. | |
| 161. | | 9. Замын | 2021- | | | | | | | | Орон нутгийн төсвөөр ALKO TEST 5000 шинэ төрлийн | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлгөөний аюулгүй байдалд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангана. /Согтуурал хэмжигч тандагч багаж, зөөврийн хурд хэмжигч/ | 2024 | | | | | | | | согтуурал тандагч 3 ширхэг багажийг Цагдаагийн хэлтсийн албан хэрэгцээнд нийлүүлсэн. Замын цагдаагийн хяналтын постод 57.0 сая төгрөгийн өртөг бүхий дундаж хурдны камерт илэрсэн зөрчлийг гар утасны дугаарт мессеж хэлбэрээр илгээх төхөөрөмжийн байршуулсан. Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 1.07 сая төгрөгөөр зөрчил шалгах төхөөрөмжийг сунгуулсан. | |
| 162. | 4.3.8. Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах эрх зүйн хөтөч буланг аймаг, сумын иргэдэд үйлчлэх төвд байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ. | 10. Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах эрх зүйн хөтөч буланг аймаг сумын нэг цонхны үйлчилгээний төвд байгуулна. | 2021-2024 | АЗДТГ | СОНХС | 16.0 | Аймагт байгуулсан эрх зүйн хөтөч булангийн тоо-1 | Аймагт байгуулсан эрх зүйн хөтөч булангийн тоо-1 | 4.0 | | Аймгийн хэмжээнд 30 иргэн эрх зүйн хөтчөөр бэлтгэгдсэн.<br>Сүмбэр сум эрх зүйн хөтчийн буланг ажиллуулж 2022 онд 1197 хүнд хууль, эрх зүйн анхан шатны үйлчилгээ үзүүлсэн.<br>Хууль зүйн үндэсний хүрээлэн, аймгийн төрийн албан хаагч эмэгтэйчүүдийг чадавхжуулах “Оюу клуб”-тэй хамтран орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад 10 байгууллагын 30 албан хаагч эрх зүйн хөтчөөр суралцаж “Хөдөлмөрийн харилцаа, Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо, Иргэний хууль ба хүний эрх, эрх чөлөө, Зөрчил түүнийг шалган шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр мэдлэгээ дээшлүүлсэн. Сургалт зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Үйл ажиллагаа явуулсан эрх зүйн хөтөч булангийн тоо – 1 | 100 |
| 163. | 4.3.9. Ялтны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуудасны биелэлтийн хувийг нэмэгдүүлнэ. | 11. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуудасны биелэлтийн хувийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ШШГГ-425 дугаар нээлттэй хорих анги | БТ | | Хоригдлын 25 хувийг ажлын байраар хангана<br><br>Гүйцэтгэх хуудасны биелэлтийн хувь-54.7 | Хоригдлын 58 хувийг ажлын байраар хангана.<br><br>Гүйцэтгэх хуудасны биелэлтийн хувь-54.8 | | | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 425 дугаар нээлттэй хорих ангиас Политехникийн коллежтой хамтран гагнуурчин, хүнд машин механизмын оператор, зам, барилгын машин механизмын операторын мэргэжлээр 44 хоригдлыг, ШШГЕГ-ын харьяа МСҮТ-ийн барилгын өрөгч угсрагч, барилгын цахилгаанчин мэргэжлээр 13 хоригдлыг сургаж, нийт 57 хоригдолд мэргэжлийн боловсрол олгож байна.<br>Хоригдлыг хөдөлмөрт хамруулах чиглэлээр гэм хорын төлбөртэй 69 хоригдлын 39 хоригдлыг цалинтай ажилд хамруулж, 73 хоригдлын 14059.0 тэрбум төгрөгийн хохирол барагдуулахаас 2022 онд 23 хоригдлын цалингаас 11.0 сая төгрөг, ар гэрээс 315.9 сая төгрөгийг бүрэн төлж барагдуулсан. Нийт хоригдлын 70 хувийг цалинтай болон цалингүй ажлын байраар хангаж ажилласан. Өмнөх оноос 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 2022 онд 345 гүйцэтгэх баримт бичгийн 20.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг биелүүлэхээр 187 гүйцэтгэх баримт бичгийн 2.2 тэрбум төгрөгийг бодитой биелүүлж 158 гүйцэтгэх баримт бичгийн 18.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 55.2 хувьтай ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ажлын байраар хангадсан хоригдлын эзлэх хувь- 70.0 хувь<br>Гүйцэтгэх хуудасны бодит биелэлт-55.2 хувь | |
| 164. | 4.3.10. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулан мэргэжлийн ангиуд, иргэдийн оролцоо, мэдлэг, чадварыг дээшлүүлэн, гамшгийн эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | 12. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн хэмжээнд сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна. | 2021-2024 | ОБГ | АОНХС | 260.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | 70.0 | | Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 арга хэмжээг төлөвлөн, 90 хувьтай хэрэгжүүлсэн.<br>Тус арга хэмжээний хүрээнд 2 удаагийн аян, 3 удаагийн нэгдсэн арга хэмжээ, 82 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан, давхардсан тоогоор 1635 иргэнийг хамруулсан.<br>Мөн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Аюулгүй жишиг гудамж” төслийг хэрэгжүүлж, гэр хорооллын 82 өрхийг хамруулан гал түймэр, гамшиг ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, гал түймэр унтраах багаж, хэрэгсэл, галын хор, аюулгүй хог хаягдлын сав, эмийн сан, анхан шатны тусламжийн иж бүрдэл зэргээр хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь | 90.0 |
| 165. | | 13. Аймгийн хэмжээнд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ. | 2021-2024 | ОБГ | УТХО | 60.0 | - | Аймгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн байна. | 60.0 | | Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 60.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төв”-тэй гэрээ байгуулан “Аймгийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г хийлгэсэн.<br>2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн хүлээн авахаар Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймгийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэн, хүлээн авах шатанд байна. | 100 |
| 166. | | 14. Онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллага, албад, мэргэжлийн анги, иргэдийн сайн дурын бүлгийг чадавхжуулах | 2021-2024 | АЗДТГ | АОНХС | | - | Зохион байгуулсан сургалт, дадлагын тоо- 5-аас доошгүй<br><br>Хамрагдсан алба | | | Мэргэжлийн байгууллага, анги, албад, иргэдийн сайн дурын бүлгийг чадавхжуулах 10 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж, 1294 албан хаагч, иргэнийг хамруулан, мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн. Үүнд:<br>1. Аймгийн Засаг даргын 2022 оны 07 сарын 04-ний өдөр баталсан “Говьсүмбэр аймгийн Гамшгаас хамгаалах албадын үер, усны аюулын голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах” ажлын удирдамжийн хүрээнд 2022 оны 07 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалт, арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | хаагчдын тоо- 500-аас доошгүй | | | сарын 05-ны өдөр аймгийн Гамшгаас хамгаалах 12 албадын 135 ажилчдын бэлтгэл бэлэн байдлыг шалгасан.<br>2. Гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын сургуулийг Шивээговь сум, “БЗӨБЦТС ТӨХК” Говьсүмбэр аймаг дахь салбар, ШШГГ- 425 дугаар нээлттэй хорих анги, бэлэн байдлын үзлэгийг И Эс Би Солар Энержи ХХК” “Сүмбэр Нарны цахилгаан станц”, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХКомпаний Чойр салбарын нийт 323 ажилтан алба хаагчдад зохион байгуулсан.<br>3. 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын хүрээнд хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр дадлага сургуулийг зохион байгуулж, төрийн болон нутгийн захиргааны 31 байгууллагын 806 иргэн, албан хаагчдыг хамруулан ажилласан.<br>4. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг тохиолдуулан Улаан загалмайн хороотой хамтран “Эрт сэрэмжлүүлэг, арга хэмжээ” уриалга дор Гамшгийн хөтөлбөрийн Улаан загалмайн сайн дурын идэвхтнүүдэд Гамшгийн эрсдэлийн тухай ойлголтын тухай сургалт болон “Хэн ч хэзээ ч хаана ч бэлэн” буухиа тэмцээнийг 10 дугаар сарын 13-ны өдөр 30 иргэнд зохион байгуулан ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалт, дадлагын тоо-10<br>Нийт хамрагдсан тоо: 1294 | |
| 167. | 4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулах, шуурхай албыг | 15. Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулна. | 2021-2024 | ОБГ | УТХО | 100.0 | - | Сургалт, арга зүйн төв байгуулна. | 100.0 | | Аймгийн Онцгой байдлын газрын дэргэд сургалт, арга зүйн төв байгуулах төсөв, зураг боловсруулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 33.3 сая төгрөгийн хөрөнгөөр Онцгой байдлын газрын хурлын танхимын тоног төхөөрөмж, компьютер, техник, хэрэгслээр хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангасан. | 70.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | авто тээврийн хэрэгслээр хангана. | | | | | | | | | | | |
| 168. | 4.3.12. Гамшгаас хамгаалах, аврах ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын газар болон мэргэжлийн байгууллагуудыг шаардлагатай техник, тоног төхөөрөмж, өндөр барилгад аврах ажиллагаа явуулах зориулалтын автотээврийн хэрэгслээр хангана. | 18. Иргэдийн сайн дурын бүлгүүдийг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана. | 2021-2024 | АЗДТГ | СОНХС | 6.0 | - | Сайн дурын хэсгийг Хөдөлмөр хамгааллын хувцсаар хангана. | 3.0 | | "Сүмбэр сумын гамшгаас хамгаалах арга хэмжээ"-ний хүрээнд 4.2 сая төгрөгөөр сумын мэргэжлийн ангийн сайн дурын бүлгийн 31 гишүүний хөдөлмөр хамгааллын хувцас, хээрийн гал түймэр унтраах багаж хэрэгсэл, анхан шатны эмийн багцаар хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сайн дурын хэсгийг 4.2 сая төгрөгийн хувцас, хэрэгслээр хангасан**.** | 100 |
| 169. | 4.3.13. Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах, хяналтын тогтолцоог сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор Хүнсний аюулгүй байдлын хяналтын лабораторийг байгуулна. | 19. Хүнсний аюулгүй байдлын лаборатори байгуулна. | 2021-2023 | АЗДТГ | УТХО | 1,235.0 | Зураг төсөв хийлгэнэ | Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | 600.0 | | Хүнсний аюулгүй байдлын лабораторийн барилгыг нэг маягийн зургаар бариулахаар саналыг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яаманд тус тус хүргүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | 30.0 |
| 170. | 4.3.14. Бүтээгдэхүүн | 20. Мэргэжлийн хяналтын газрын | 2021-2024 | АЗДТГ | УТХО | 1,152.5 | | Мэргэжлийн хяналтын | 500.0 | | Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн үйл ажиллагааг бэхжүүлж, орон нутгийн төсвийн 50.8 сая | 50.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанар, хүрээлэн байгаа орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах, аж ахуйн нэгж байгууллагууды | контор, лабораторийн барилгыг ашиглалтад оруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | | | | | | газрын контор, лаборатори йн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | | | төгрөгийн 14 нэр төрлийн лабораторийн багаж, тоног төхөөрөмжөөр хангасан.<br>Мэргэжлийн хяналтын газрын контор, лабораторийн барилгын зураг, төсвийг шинэчлэн боловсруулж, улсын төсөвт тусгуулахаар саналыг хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Лабораторийн тоног төхөөрөмжөөр хангасан.<br>Барилгын ажлын төсвийг шинэчлүүлэн, улсын төсөвт саналыг хүргүүлсэн. | |
| 171. | н үйл ажиллагаанд зөвлөн туслах, стандартыг мөрдүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор Мэргэжлийн хяналтын газар болон бусад мэргэжлийн байгууллагууды г авто тээврийн хэрэгсэл, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаан, чадавхыг нэмэгдүүлнэ. | 21. Хяналт, шалгалт, зөвлөн туслах арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлнэ. | 2021-2024 | МХГ | БТ | | 12 ерөнхий үнэлгээ хийлгүүл ж баталгаа жуулсан. | Эрсдэлийн үнэлгээ хийх -1000-аас доошгүй объект<br>Их эрсдэлтэй-22 хувиас доош | | | 2022 онд 6 иргэн, 4 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 10 зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэв. Зөвлөн туслах үйлчилгээний явцад 85 зөрчил илрүүлж, 27 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 58 зөрчлийг арилгуулахаар 7 газарт зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн.<br>3 чиглэлийн хяналт шинжилгээнд 5 сургууль, нийтийн эзэмшлийн тоглоомын 5 талбай, 11 төвлөрсөн усны цэгийг хамруулав.<br>1 урьдчилан сэргийлэх хяналт, 3 салбарын сургалтыг зохион байгуулж, 8 аж ахуйн нэгжийн 71 ажилтанг хамруулсан.<br>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй.<br>Төвлөн туслах хяналт-10, хяналт-шинжилгээ–3, урьдчилан сэргийлэх хяналт-1 сургалт–3–ыг тус тус зохион байгуулж, 36 аж ахуйн нэгж, обьект, 71 ажилтанг хамруулсан. | 70.0 |
| 172. | 4.3.15. Орон нутгийн аюулгүй байдлыг хангах үүднээс бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий хүнсний агуулах | 22. Махны болон хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий агуулах барихыг дэмжинэ. | 2021-2024 | ХХААГ, СЗДТГ | ХХО, ЖДҮДС, СХС | | Дэмжлэг авсан махны зоорины тоо-1<br><br>Шинээр байгуулсан зоорины тоо-3 | Махны болон хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий агуулах барихыг зээлийн болон газрын бодлогоор дэмжинэ. | | | Сүмбэр сумын “Очир мөнх хайрхан” ХХК 2019 онд ЖДҮХС-ийн 60 сая төгрөгийн зээлийн дэмжлэгээр стандартын шаардлага хангасан 100 тн багтаамжтай зоорь, нэг агуулахыг шинээр барьж 2022 онд ашиглалтад оруулсан. Мөн Баянтал сумын “Оорцог элгэн хоршоо”-ны 80тн багтаамжтай агуулах байгуулах төсөлд ЖДҮХСангаас зээл олгохоор дэмжигдсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр нэмэгдсэн зоорь, агуулахын тоо-1<br>Зоорь, агуулах барих чиглэлээр зээлийн дэмжлэг авсан аж ахуй нэгжийн тоо-1 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | барихыг дэмжинэ. | | | | | | | | | | | |
| 173. | 4.3.16. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулна. | 23. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулна. | 2021-2024 | Цагдаагийн хэлтэс | БТ | | Зохион байгуулсан сургалтын тоо-23 Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-352 | Зохион байгуулсан сургалтын тоо-2 Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-150 | | | Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд нийт 20 сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1257 иргэнийг хамруулсан. Үүнд:<br>Ерөнхий боловсролын 5 сургууль, Политехникийн коллежийн 840 сурагч хүүхдүүд, оюутан залууст гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архины хор уршгийг ойлгуулан таниулах сургалтыг зохион байгуулсан.<br>“Зөвийг зөвлөе” арга хэмжээг зохион байгуулж, архины хор хөнөөлийн талаар 6 төрлийн 570, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 төрлийн 450, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 төрлийн 710, нийт 14 төрлийн 1730 ширхэг гарын авлага, тараах материалыг бэлтгэн, иргэдэд хүргэсэн. “Говьсүмбэр телевиз”-ээр 3 удаагийн нэвтрүүлэг, аймгийн FM радиогоор 4 удаагийн нэвтрүүлгийг хүргэж, “Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс” пейж хуудаст 6, “Говьсүмбэр аймгийн цагдаа” фейсбүүк хуудаст 36 мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг баар 1, караоке 4, ресторан 5, найман нэрийн дэлгүүр 43, нийт 49 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архины хор хөнөөлийг иргэдэд сурталчлах чиглэлээр уриалга гарган хүргүүлсэн.<br>12 төрлийн зөвлөмж, мэдээлэл, “Зөвийг зөвлөе” арга хэмжээний лого бүхий 650 зурагт хуудсыг цахимаар болон худалдаа, үйлчилгээний төв, дэлгүүр, ШТС, хүнсний дэлгүүрүүд, орон сууцны орц зэрэг олон хүн цугладаг цэгүүдэд байршуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо-20<br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-1257 | 100 |
| 174. | | 24. Архинд донтох эмгэгтэй иргэдийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна. | 2021-2024 | Цагдаагийн хэлтэс | БТ | | Албадан болон сайн дурын эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-31 | Албадан болон сайн дурын эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-2 | | | Аймгийн Цагдаагийн хэлтэс, Сүмбэр сумын Засаг даргаас Боржигоны оточ эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу Сүмбэр сумын 16 иргэнийг архинаас гаргах сайн дурын эмчилгээнд 2022.04.22-24-ны өдрүүдэд хамруулсан. 10 иргэний эмчилгээний зардал 4,950,000 төгрөгийг Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас, 6 хүний эмчилгээний зардал 2,970,000 төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шийдвэрлэсэн.<br>Сүмбэр сумын хэмжээнд Архигүй Сүмбэр 1,2,3 арга хэмжээг зохион байгуулж 47 иргэн хамрагдсан. Архины | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | эмчилгээнд хамрагдсан нийт иргэдийн 12 буюу 25 хувь нь архи согтууруулах ундааг дахин хэрэглэж эмчилгээний үр дүн 75 хувьтай байна.<br>Архидан согтуурах болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүчирхийлэлгүй гэр бүл Хүчирхийлэлгүй ирээдүй” 2 сарын аяныг зохион байгуулан ажилласан. Аянд хамрагдсан 43 өрхөөс 29 өрхийн хүчирхийллийн нөхцөл байдал арилж 45 хүүхдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөл боломж бүрдсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Архинаас гаргах эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-45 | |
| 175. | 4.3.17. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдалд хяналтыг эрчимжүүлнэ. | 25. Мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалт хийж, эрсдэлийг бууруулан аюулгүй байдлыг хангуулна. | 2021-2024 | МХГ, ОБГ | БТ | | Хяналт, шалгалтын тоо – 4<br>Эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй байгууллагын тоо -4<br>Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын эзлэх хувь – | Хяналт шалгалтын тоо -4-өөс доошгүй<br><br>Эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй байгууллагын тоо-8-аас доошгүй<br><br>Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын эзлэх хувь-45 хувиас доошгүй | | | Аймгийн хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний 6 агуулах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн 2 агуулах үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022 онд газрын тосны агуулах бүхий 5 аж ахуйн нэгж, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн 1 агуулахад хяналт, шалгалт хийж, зөвлөн туслах арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>Онцгой байдлын газраас “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, худалдан борлуулах цэгүүдэд Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт”-ын талаар 11 аж ахуйн нэгж, байгууллагад сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 122 ажилтан, албан хаагчид хамрагдсан.<br>Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүд 100 хувь эрсдэл бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хяналт, шалгалтын тоо – 5<br>Эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй байгууллагын тоо -5<br>Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын эзлэх хувь – 68.5 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 66.7 | | | | | |
| 176. | 4.3.18. Шүүхийн шинжилгээний байгууллагын чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 26. Шүүхийн шинжилгээний байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 2021-2024 | АЗДТГ | УТХО<br>АОНХС | 100.0<br>41.0 | - | Цогцос зөөвөрлөх тоноглогдсон авто машинаар хангана. | 100.0 | | Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 28.5 сая төгрөгөөр эд, эс зүслэгийн аппаратыг “Сүвэн Ул ХХК”-аас худалдан авч, Шүүхийн шинжилгээний албанд хүлээлгэн өгсөн.<br>Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс тусгай зориулалтын автомашинаар хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо-1<br>Автомашины тоо - 1<br>Зарцуулсан санхүүжилт: ОНТ-28.5 сая, төгрөг | 100 |
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | | **92.0** |
| **Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл** | | | | | | | | | | | | |
| **4.4. Хүний эрх, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.** | | | | | | | | | | | | |
| 177. | 4.4.1. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй оролцогчийн эрхийг хангахад Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллана. | 1. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй оролцогчийн эрхийг хангахад Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | 2021-2024 | Хууль зүйн туслалцааны төв | ОНТ | - | Өмгөөллийн туслалцаа үзүүлсэн тоо-186<br><br>Зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэдийн тоо-30 | Хууль зүйн туслалцааны төвийг байраар хангана. | | | Хууль зүйн туслалцааны төвийн Говьсүмбэр аймаг дахь улсын өмгөөлөгчийг аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд иргэд, үйлчлүүлэгчдийн нууцлалыг хадгалах боломж бүхий өрөөгөөр хангаж урсгал зардлыг хариуцан, интернэтийн орчинг бүрдүүлэн ажиллаж байна.<br>2022 онд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөс 23 хэргийн 28 хүнд өмгөөллийн туслалцаа үзүүлж, шүүхээр 17 хэргийн 18 хүний асуудлыг шийдвэрлүүлэн, шүүхийн өмнөх шатанд 2 хэргийн 2 хүн, татгалзсан 1 хэргийн 3 хүн, шүүхээр шийдвэрлэгдээгүй 2 хэргийн 1 хүн байна. 132 иргэнд хуулийн зөвлөгөө өгч ажилласан.<br>Хууль зүйн туслалцааны төв болон төрийн байгууллагаас иргэдийн эрх зүйн боловсролд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 81 төрлийн мэдээллийг 539 иргэнд хүргэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Өмгөөллийн туслалцаа үзүүлсэн тоо-28<br>Зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэдийн тоо-132 | 100 |
| 178. | 4.4.2. Гэмт хэрэг зөрчлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ. | 2. Хүү торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөнө. | | | | | | | | | 2021 оны орон нутгийн төсөвт 2019 оны хүү торгуулийн орлогын 40 хувь 128.8 сая төгрөгийг аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар тусган баталсан. Тус арга хэмжээний зардлын 50.4 сая төгрөгөөр Цагдаагийн хэлтэс,Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шинжилгээний албыг тус тус тоног төхөөрөмжөөр хангаж, олон нийтийн 9 цагдаагийн цалинг шийдвэрлээ, 18.0 сая төгрөгөөр эргүүлийн автомашин худалдан авч аймгийн Цагдаагийн хэлтэст олгосон. Албадан саатуулах эрүүлжүүлэх байранд урсгал засвар хийсэн бөгөөд 2022 оны аймгийн Орон нутгийн | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хөгжлийн сангийн хөрөнгөөр их засвар хийхээр төсвийг баталсан. Тус арга хэмжээ нь ЗДҮАХ-ийн 2022 оны төлөвлөлтөд ороогүй учир тайлагналт 2021 онд хэрэгжсэнээр тайлагнаж байна. | |
| 179. | 4.4.3. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ. | 3. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ. | 2021-2024 | ОНӨГ | БТ | | Хяналт тавьж ажиллаж байгаа байгууллагын тоо – 43 | Өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад гүйцэтгэлийн болон баримтын шалгалт хийх, бүртгэлээр хяналт тавьж ажиллах байгууллагын тоо-43<br><br>Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ. | | | 2022 оны орон нутгийн өмчит 43 байгууллагатай “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г байгуулж, гэрээний хэрэгжилт дунджаар 81.4 хувь буюу хангалттай үнэлэгдэв.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчтэй 27, орон нутгийн өмчтэй 43, нийт 70 хуулийн этгээд хамруулж, 43 байгууллагын үндсэн хөрөнгийг цахим системд бүртгэж, нийт 87.8 тэрбум төгрөгийн эд хөрөнгө тоологдсон.<br>2022 онд аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн 38 нэр төрлийн 165,639,800 төгрөгийг бүртгэлжүүлж, 5 нэр төрлийн 213,063,032,200 төгрөгийн өртөг бүхий өмч хөрөнгийг шилжүүлж, 259,853,013 төгрөгийн өмч хөрөнгийг дахин үнэлж, үнийг шинэчлэн тогтоож, 579 нэр төрлийн 1,226,366,443 төгрөгийн өмч хөрөнгийг акталж устгасан.<br>Орон нутгийн өмчийн оролцоотой 43 хуулийн этгээдүүдийн улсын бүртгэлийн гэрчилгээний зөрчилтэй 11 байгууллагын зөрчлийг арилгаж, 20 байгууллагын газрын цахимжуулалтыг хийсэн, тоон гарын үсгийг 20 байгууллагад олгох тухай зөвлөгөө өгч, 6 байгууллагын автомашины бичиг баримтын зөрчлийг арилгуулсан.<br>43 байгууллагын хөрөнгийн хөдөлгөөнийг www.haaa.gs.gov.mn сайтаар бүртгэлжүүлэн, цахимжуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад гүйцэтгэлийн болон баримтын шалгалт хийх, бүртгэлээр хяналт тавьж ажиллах байгууллагын тоо-43<br>Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.<br>Акталж данснаас хасах хөрөнгийн хэмжээ-1,226,366,443 төгрөг<br>Бүртгэлжүүлсэн хөрөнгийн хэмжээ-165,639,800 төгрөг<br>Данс хооронд шилжүүлсэн хөрөнгө байхгүй. | 100 |
| 180. | 4.4.4. Орон нутагт хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах ажлыг | 4. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | АОНХС | 40.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | 10.0 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/73 дугаар захирамжаар “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд 3 зорилтын 14 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан. Үүнд:<br>Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулдаг “Хуульчийн про боно өдөр-2022” арга хэмжээг зохион | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ. | | | | | | хувь- 66.6 | | | | байгуулж, 150 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Прокурорын газар, Өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран хар тамхи, мансууруулах бодис, ялгаварлан гадуурхалт, сэтгэцэд нөлөөлөх бодис, иргэний бичиг баримт бүрдүүлэх сэдвээр сургалт зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 30 сурагчийг хамруулсан.<br>Прокурорын газар, Монголын өмгөөлөгчдийн зөвлөл, Мэргэжлийн хяналтын газартай хамтран Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, Барилгын тухай хууль, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг сэдвээр подкаст бэлтгэн цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр 4986 иргэнд хүргэсэн.<br>Авлигатай тэмцэх газар, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулиар нийт 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 357 иргэнийг хамруулсан.<br>Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, тогтоомж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн 17 удаагийн сургалтыг зохион байгуулж, 438 төрийн албан хаагчийг хамруулсан.<br>Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, тогтоомж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн 17 удаагийн сургалтыг зохион байгуулж, 438 төрийн албан хаагчийг хамруулсан.<br>Мэдээллээс хол байдаг хөдөөгийн малчдад зориулж тэдний гар утсанд Хөдөлмөрийн тухай хуулиар эрх зүйн мэдээлэл хүргэж ажилласан. Нийт 1008 малчин иргэдэд мэдээлэл өгсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь- 100 хувь. | |
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | | **100** |
| **Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого** | | | | | | | | | | | | |
| **4.5. Гадаад харилцаанд нэг цонхны нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэн, хөрш орнууд болон гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх** | | | | | | | | | | | | |
| 181. | 4.5.1. Гадаад хамтын ажиллагааг | 1. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга | 2021-2024 | АЗДТГ | АОНХС | 75.0 | Тухайн жилийн арга | Тухайн жилийн арга хэмжээний | 15.0 | | "Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ"-г төлөвлөн 11 багц арга хэмжээг 80.0 хувьтай хэрэгжүүлсэн. Гадаад хамтын ажиллагаа, гадаадын | 80.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, Олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаа, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг гадаад хамтын ажиллагааны хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь бодлогоор дэмжинэ. | хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны болон сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллана. | | | | | хэмжээний хэрэгжилтийн хувь-84.2 | хэрэгжилтийн хувь-100 | | | хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд 6 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. БНХАУ-ын Жиангсу мужийн Үши хоттой найрсаг харилцаа, хамтын ажиллагаа тогтоох санамж бичгийг 2022 оны 03 дугаар сарын 18–ны өдөр албан ёсоор баталгаажуулсан. БНСУ-ын Гёнсанбүг мужад зохион байгуулсан “NEAR 2022” олон улсын форумд төрийн байгууллагын 5 албан хаагч цахимаар хамрагдсан. Гадаад улсад уралдаан, тэмцээнд оролцох 2 хамтлаг, 7 иргэнд 16.5 сая төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын нөөц сангаас олгосон. Гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, гадаад сургалтад хамрагдах, туршлага судлахад 3 төрийн албан хаагчид 4.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Орон нутагт олон улсын байгууллагуудтай хамтран 6 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>1. Шинжлэх ухааны Геоэкологийн хүрээлэн, БНХАУ-ын Шинжаан Уйгарын Цөлжилтийн судалгааны хүрээлэнтэй хамтран говь, цөлийн бүсэд тохирох ургамлын плантаци байгуулах, 10 000 ш модлог ургамлыг үрээр бэлтгэх.<br>2. Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулагдсан хөнгөлөлттэй зээлээр дулааны станц байгуулах төсөл.<br>3. Японы нийгмийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламж, Дэлхийн банкны “Хүүхдийг ивээх сан”-аас “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд “ESEL” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 48 хүүхэд, залуучуудыг хамруулан, 5 төсөлд 22.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br>4. Дэлхийн Зөн ОУБ-ын Бор-Өндөр ОНХХ-ийн хүрээнд “Хамтдаа хөгжсөн 18 жил” арга хэмжээг зохион байгуулсан.<br>5. Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийг хэрэгжүүлэн 2016-2022 онд 22 бичил төсөлд 214.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>6. Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Бохир усны цэвэрлэх байгууламж барих” ажлыг эхлүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт – 80 хувь | |
| 182. | | 2. Монгол Улс, Оросын холбооны улс, Бүгд найрамдах Хятад ард улс | 2021-2024 | АЗДТГ | ОНХС, ХХО | | Зохион байгуулсан арга хэмжээ-3 | Форум, уулзалт, сургалт, үзэсгэлэн | | | Гурван улсын хамтын ажиллагааны хүрээнд “Цайны зам” Олон улсын аялал жуулчлалын форумд цахимаар 5 төлөөлөгч оролцсон.<br>ОХУ-аас БНХАУ-руу Монгол улсын нутаг дэвсгэрээр | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хоорондын хамтын ажиллагааны хүрээнд улс, төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, боловсрол, хүмүүнлэгийн болон бусад салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн, зохион байгуулагдах форум, уулзалт, үзэсгэлэн худалдаанд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг оролцуулна. | | | | | | худалдаа, туршлага судлах арга хэмжээнд оролцсон төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл - 20-оос доошгүй | | | тавигдах хий дамжуулах хоолойн төслийг гүйцэтгэгч "Газопровод Союз Восток" ХХК-ийн удирдлагуудтай аймгийн удирдлагууд 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж, төслийн үйл явц, талаар мэдээ, мэдээлэлтэй танилцсан.<br>"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн ерөнхий инженер Старрцев Сергей Петровичоор ахлуулсан ажлын хэсгийг орон нутагт хүлээн авч тус байгууллагын харьяа уурын зуух, цэвэр, бохир усны инженерийн шугамыг орон нутагт шилжүүлэх чиглэлээр санал солилцлоо.<br>БНХАУ-ын Жиангсу мужийн Үши хоттой найрсаг харилцаа, хамтын ажиллагаа тогтоох санамж бичгийг 2022 оны 03 дугаар сарын 18–ны өдөр албан ёсоор баталгаажуулсан.<br>ОХУ-ын Ангарск муж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ухай хоттой хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар саналаа ГХЯ-д хүргүүлээд байна.<br>ОХУ-ын элчин сайдын яам, Орос-Монголын найрамдлын нийгэмлэгтэй хамтран ОХУ-ын соёлын өдөрлөг, Орос хэлний бүсийн олимпиад, Орос дууны уралдаан зэргийг орон нутагт зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 5 аймгийн 80 хүүхэд, залуус оролцсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамтын ажиллагааны хүрээнд 1 хоттой санамж бичиг байгуулж, гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан 4 уулзалтад 6 албан хаагч оролцсон.<br>Орон нутагт 3 удаагийн уулзалт зохион байгуулж, 80 гаруй албан хаагч оролцсон. | |
| 183. | | 3. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд Япон, БНСУ, Турк болон бусад улс, орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | АОНХС | | Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо-6 | Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо-8-аас доошгүй | | | 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр "NEAR 2022"- Олон улсын форумд Говьсүмбэр аймгаас цахимаар 2 төлөөлөгч оролцсон. БНСУ-ын Гёнсанбүг мужад "6 дахь аж үйлдвэрийн хөгжлийг Зүүн хойд Азийн хөдөө тосгон, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний аж үйлдвэрийн ирээдүйн хөгжлийн стратегитай уялдуулах нь" сэдвээр олон улсын форумд 5 албан хаагч хамрагдсан. Аймгийн Засаг дарга Дэлхийн Зөн ОУБ-ын бүсийн захирал Анжа Гоулдтай 2022 оны 04 дүгээр сарын 11–ний өдөр уулзаж, Говьсүмбэр аймагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүн, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон. Дэлхийн банк, Ю-Пи-Си ХХК-ийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын нутагт хэрэгжих 50.4МВт-ын хүчин чадалтай "Чойрын салхин парк" төслийг хэрэгжүүлэхээр орон нутагт уулзалт зохион байгуулж, 25 хүн оролцсон. БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 20Гкал/ц хүчин чадалтай дулааны станцыг 2024 онд ашиглалтад оруулах ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн явцад мониторинг хийх төслийн багтай 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Япон улсын Засгийн газрын дэргэдэх Өвсний үндэс хөтөлбөрт 8 төслийн саналыг хүргүүлсэн. БНСУ-ын Мүгфу хоттой хөдөлмөрийн гэрээт ажилтан ажиллуулах чиглэлээр хамтран ажиллахаар хэлэлцээр хийгдэж байна. Бүгд найрамдах Турк улсын Гүмүшхане хот, Унгар улсын Сароспатак хот, БНСУ-ын Чангвон хоттой хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар саналаа ГХЯ-д хүргүүлээд байна. Японы Засгийн газрын дэргэдэх Хүүхдийг ивээх сангийн санхүүжилтээр “Орон нутагт Энтерпринёршип хөтөлбөр”-ийг 3 дахь жилдээ хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудын санаачилсан 19 төсөлд 53.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. АНУ-ыг Энхтайвны корпустай хамтран ажиллаж эрүүл мэндийн салбарт 1 сайн дурын ажилтанг ажиллуулж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>5 хоттой хамтын ажиллагаа тогтоохоор ажиллаж байна.<br>Хамтран хэрэгжүүлэхээр хүргүүлсэн төслийн тоо - 3<br>Орон нутагт зохион байгуулсан арга хэмжээний тоо – 1 | |
| **Зорилтын дундаж хэрэгжилт** | | | | | | | | | | | | **90.0** |
| **Батлан хамгаалах** | | | | | | | | | | | | |
| **4.6. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.** | | | | | | | | | | | | |
| 184. | 4.6.1. Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | 1. Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | 2021-2024 | Цэргийн штаб | АОНХС | 80.0 | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br><br>Зохион байгуулах сургалтын тоо-1 | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 100<br><br>Зохион байгуулах сургалтын тоо-1 | 20.0 | | Сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хянаж, тодотгол хийн, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдэд бие бүрэлдэхүүнийг шинэчлэн томилгоожуулсан.<br>Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулж, сумын ЗДТГ-ын дарга нар болон багийн Засаг дарга нарыг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 хувь<br>Зохион байгуулсан сургалтын тоо-1 | 100 |
| 185. | 4.6.2. “Хүүхэд, залуучуудад эх | 2. “Хүүхэд, залуучуудад эх | 2021-2024 | Цэргийн | АОНХ | | Шинээр суралцс | Шинээр суралцсан | | | 2022 онд манай аймагт шинээр суралцах оюутан цэргийн хувиар ирээгүй. | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлж, "Оюутан-цэрэг" сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ. | оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлж, "Оюутан-цэрэг" сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ. | | штаб | С | | ан оюутан цэргийн тоо-0<br><br>Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Дөл" цэрэг спортын тэмцээнийг зохион байгуулаагүй. | оюутан цэргийн тоо-2<br><br>Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Дөл" цэрэг спортын тэмцээнийг зохион байгуулна.<br><br>Оюутнуудад Цэргийн анхан шатны сургалт зохион байгуулна. | | | Өсвөр үе, хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэх зорилгоор аймгийн цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнд 3 сумаас шалгарсан 8 багийн 90 гаруй сурагч оролцож, цэрэг, спортын 12 төрөлд ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуужлаа сорьж эхний 1, 2 дугаар байр эзэлсэн 13 сурагчийн бэлтгэлийг хангуулан улсын "Дөл" цогцолбор тэмцээнд оролцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр суралцсан оюутан цэргийн тоо-0<br>Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Дөл" цэрэг спортын тэмцээнийг зохион байгуулсан<br>Оюутнуудад зохион байгуулсан сургалтын тоо - 0 | |
